



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

2014

ЖИЛИЙН ТАЙЛАН

ГАРЧИГ

ӨМНӨТГӨЛ	4
ЗАСАГЛАЛЫН ХӨТӨЛБӨР	
Хүний эрх	8
Хууль сахиулах ажиллагааны ил тод байдал	14
Эрх зүйн шинэчлэл	17
Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь	19
Улс төрийн санхүүжилт	23
Төрийн ил тод хариуцлагатай байдал	29
Хэвлэлийн эрх чөлөө	29
Байгаль орчны талаар мэдээлэл авах иргэдийн эрхийг баталгаажуулах нь	31
Хариуцлагатай байдлыг бэхжүүлэх механизм	35
Иргэний нийгмийн чадавхыг бэхжүүлэх	37
ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ХӨТӨЛБӨР	
Олборлох үйлдвэрлэлийн засаглал, тод байдал	42
Төсвийн ил тод байдал ба иргэдийн оролцоо	48
Эдийн засгийн хөгжлийн дүн шинжилгээ ба бизнесийн орчин	53
Төрийн өмчит компаниудын засаглал	59
БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН ХӨТӨЛБӨР	
Тэгш хамруулах боловсрол	64
Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих	69
Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх нь	72
САНХҮҮЖИЛТ, АЖИЛТНУУД	75

ТОВЧИЛСОН ҮГ

ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БОНХАЖЯ	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам
ДӨЧИ	Дэлхийн өрсөлдөх чадварын индекс
ДЭЗФ	Дэлхийн Эдийн Засгийн Форум
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МСҮТ	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв
МУИС	Монгол Улсын Их Сургууль
МҮОНРТВ	Монголын үндэсний олон нийтийн радио телевиз
ННФ	Нээлттэй Нийгэм Форум
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОҮИТБС	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга
ӨАБНУ	Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс
СХС	Сум хөгжүүлэх сан
ТАН эвсэл	Төлсөн Авснаа Нийтэл
ТББ	Төрийн бус байгууллага
ТЕГ	Тагнуулын ерөнхий газар
УЕПГ	Улсын ерөнхий прокурорын газар
УИХ	Улсын Их Хурал
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд
ХЭҮК	Хүний эрхийн үндэсний комисс
ХЗС	Хууль зүйн сургууль
ХЗТТ	Хууль зүйн туслалцааны төв
ХЗЯ	Хууль зүйн яам
ХХЗХ	Харилцаа холбооны зохицуулах хороо
ХХИ	Хэрэглэгчийн хүлээлтийн индекс
ХУД	Хан-Уул дүүрэг
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ХЭЗ	Хүний эрхийн зөвлөл
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар

ӨМНӨТГӨЛ

Төрийн ил тод, хариуцлагатай байдлыг гүнзгийрүүлэх, улс орныхоо хөгжлийн оновчтой бодлого боловсруулахад тус нэмэр болох зорилгоор идэвх зүтгэл гарган ажилласан нэгэн жилийн ажлын тайлангаа Таны гарт хүргэж байгаадаа таатай байна. 2014 он Нээлттэй Нийгэм Форум (ННФ)-ын хамт олон бидний хувьд 2014-2017 оныг хамарсан шинэ стратегиа хэрэгжүүлэх эхний хариуцлагатай жил байлаа. Бид энэхүү шинэ стратегийн дагуу Засаглал, Эдийн засгийн бодлого, Боловсрол, нийгмийн бодлого болон Шүүх, Хууль сахиулах салбарын шинэтгэлийн хөтөлбөрийн хүрээнд үйл ажиллагаагаа явууллаа.

Ардчилал, шударга ёсыг бэхжүүлэх, хүний эрх, хүрээлэн буй орчныг хамгаалахад бодитой, тууштай хувь нэмэр оруулж буй иргэний нийгмийн байгууллагуудыг нийтийн эрх ашгийн төлөө чухалчлан ажиллаж буй асуудлаар нь дамжуулан олон нийтэд таниулах, улмаар институцийн хувьд бэхжүүлэх дэмжлэг үзүүлээ. Энэ хүрээнд төрийн бус байгууллагуудын нийгмийн сайн сайхны төлөө явуулж буй үйл ажиллагааг олон нийтийн зүгээс үнэлэх үнэлэмж, дэмжлэгийг дээшлүүлэхэд тус дөхөм үзүүлнэ гэж найдаж 8 сэдвээр богино хэмжээний видео нийтлэл бэлдэж олны хүртээл болголоо.

Хууль сахиулах салбарын шинэтгэлийг дэмжих зорилгоор Хууль зүйн яамтай байгуулсан Санамж бичгийн хүрээнд үйл ажиллагааны стандартыг хүний эрхэд нийцүүлэх, сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, алба хаагчдыг чадавхжуулах, шинэ тутам бий болсон хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааны баримт бичиг боловсруулахад холбогдох төрийн байгууллагуудтай хамтран ажиллалаа. Тухайлбал, хууль сахиулах ажиллагаатай холбогдох 51 баримт бичиг боловсруулж, 109 бичиг баримт орчуулж, ННФ-аас зохион байгуулсан 19 төрлийн сургалтад 807 алба хаагч хамрагджээ.

Шүүхийн шинэтгэлийн үйл явцыг үнэлэх “Шүүхийн ажиглалт” судалгааг хоёр дахь удаагаа хийлээ. Шүүхийн үйл ажиллагааг шинэтгэлийн өмнөхтэй харьцуулах зорилгоор 2010 онд хамрагдаж байсан аймгуудын сум дундын шүүх, дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийг сонгон авч явууллаа. Түүнчлэн шүүхийн шинэтгэлийг үр нөлөөтэй явуулахад шударга, хараат бус шүүгчийн үйл ажиллагаа болон иргэдийн төлөөлөгчийн гүйцэтгэх үүрэг чухал



билээ. Иймээс бид энэ чиглэлээр судалгаа шинжилгээ, гарын авлага гаргаж өргөн хүрээний хэлэлцүүлэг өрнүүллээ. Хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавьж, эрхийг хамгаалах үндэсний механизмыг бэхжүүлэхэд бид олон жилийн туршид тууштай ажиллаж байна. 2014 онд ННФ-ын дэмжлэгтэйгээр Хүний эрхийн төрийн бус байгууллагуудын Форум НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлд нийт 12 сэдвээр тайлан бэлтгэж хүргүүллээ. Мөн хүний эрхийн мэдлэг, мэдээлэл түгээх хүрээнд цуврал лекц, уулзалт, хэлэлцүүлгүүд зохион байгууллаа.

ННФ үйл ажиллагааны шинэ стратегид агуулсан улс төрийн санхүүжилтийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, түүний ил тод, хариуцлагатай байдлыг хангах нь манай орны ардчилсан хөгжлийн нэн тулгамдсан асуудал хэмээн томъёолж, энэ үйл явцыг дэмжих үүднээс судалгаа шинжилгээ, мониторинг хийх, иргэдийн мэдлэг ойлголтыг гүнзгийрүүлэх, тэдний санал бодлыг судлах зэрэг ажил хийлээ. Улс төрийн санхүүжилтийн талаар иргэдийн дунд явуулсан судалгаанд 1000 гаруй хүн оролцож санал бодлоо илэрхийлсэн нь цаашид улс төрийн санхүүжилтийн эрх зүйн орчныг боловсронгуй болгоход чухал хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна.

Төрийн ил тод, хариуцлагатай байдал, төсвийн зарцуулалт, иргэдийн оролцоо, уул уурхайн салбарын хууль тогтоомж, гэрээний хэрэгжилтийг хянах чиглэлээр 23 төрийн бус байгууллага мониторинг хийж дүнгээ гаргаж эхлээд байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрийн бус байгууллагуудын сүлжээ болон Хүүхэд хамгааллын үндэсний сүлжээнээс хэрэгжүүлсэн стратегийн өмгөөллийн үр дүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийтийн тээврээр зорчих эрхийг хязгаарласан стандарт хүчингүй болж, дотуур байрны хүүхэд хамгааллын асуудалд төрөөс анхаарал хандуулж, үндэсний хэмжээний суурь судалгаа хийхэд хүргэв. Түүнчлэн байгаль орчны мэдээллийг ил болгох зорилгоор хэрэгжүүлсэн загвар төслийн хүрээнд иргэд мэдэх эрхээ эдлэх, шаардах хандлага, дадал бүрэлдэж, цаашид төрийн зүгээс Туул гол орчмын бохирдлын мэдээллийг ил болгох, бохирдол үүсгэж байгаа үйлдвэр аж ахуйн газрын байгаль орчны нөлөөллийг нарийвчлан судлах чиглэлээр арга хэмжээ авахад нөлөө үзүүлэв.

Олборлох үйлдвэрлэлийн салбарын ил тод байдлыг хангах эрх зүйн орчныг сайжруулах, эрдэс баялгийн салбар дахь гэрээний ил тод байдлыг хангах, ОУИТБС, түүний шинэ стандартыг хэрэгжүүлэх чиглэлээр иргэний нийгмийн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэхэд голлон анхаарав. Гадаад орнуудын ОУИТБС-ын тухай хууль тогтоомжийн харьцуулсан судалгаа хийж, холбогдох талуудад хүргүүллээ. Мөн төр, олборлох үйлдвэрлэл эрхлэгчид болон иргэний нийгмийнхний ойлголт, байр суурийг нэгтгэх, хамтын ажиллагааг бэхжүүлэхийг зорьж “Эрдэс баялгийн салбар дахь гэрээний ил тод байдал” олон талт хэлэлцүүлгийг УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо, Уул уурхайн яам, ОУИТБС-ын Ажлын алба, ТАН эвсэл, Уул уурхайн үндэсний ассоциаци зэрэг талуудтай хамтран зохион байгууллаа. Уул уурхайн яамтай хамтран

төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 9 компанийн засаглалын өнөөгийн түвшинг үнэлэв. Тэрчлэн энэхүү судалгааны аргачлалыг ашиглан мөн төрийн өмчит эрчим хүчний 13 компанийн засаглалын түвшинг үнэлэх судалгааг эхлүүлээд байна.

ННФ 2014 онд төсвийн ил тод байдлыг үндэсний болон орон нутгийн түвшинд үнэллээ. Тав дахь удаагаа хийгдсэн Монгол Улсын төв засгийн газрын төсвийн ил тод байдлыг үнэлэх судалгааны урьдчилсан дүнгээс харахад төсвийн ил тод байдал дорвитой сайжраагүй хэвээр байна. Орон нутагт ч төсвийн ил тод байдал хангалтгүй байна. 2015 оны 1 сарын 1-нээс хэрэгжиж эхлэх Шилэн дансны хуулийн төсвийн ил тод, хяналттай байдлыг хангахад гүйцэтгэх нэн чухал үүргийг харгалзан энэхүү хуулийн хэрэгжилтэд мониторинг хийх төрийн бус байгууллагуудыг чадавхжуулахад онцгой анхаарлаа.

Боловсрол, нийгмийн бодлогын хүрээнд боловсролд тэгш хамруулах, бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагуудыг чадавхжуулах, залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх бодлого, стратегийн суурийг тавих хэтийн зорилготой судалгааны ажлууд хийгдлээ. Манай оронд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тусгай сургуульд сургаж байгаа нь тэднийг цаашид нийгмийн амьдралд бие даан оролцох боломж бололцоог хязгаарлаж буй хэрэг юм. Иймээс боловсролын салбарт идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа төрийн захиргааны болон төрийн үйлчилгээ үзүүлдэг байгууллага, иргэний нийгмийнхэн болон эцэг эхийн холбоодыг нэг дор цуглуулж төрөөс баримтлах бодлогын талаарх үзэл бодол, хандлага ойлголтоо хэлэлцэн нэгтгэхэд бид анхаарч ажиллав. Үүний үр дүнд төр, иргэний нийгмийн түншлэл, хамтын ажиллагаа төлөвших эхлэл тавигдлаа.

Ийнхүү нэг жилийн хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлаа тоймлон хүргэхийн ялдамд 2014 онд бидэнтэй хамтран ажилласан төрийн болон төрийн бус байгууллагууд, судлаачид, хувь хүмүүст талархсанаа илэрхийлье. Манай ажлын талаар санал, зөвлөгөөгөө хуваалцах аваас бид ямагт талархан хүлээн авах болно.

Гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал



ЗАСАГЛАЛЫН ХӨТӨЛБӨР

Хууль сахиулах салбарт хэрэглэгдэх олон улсын 109 жишиг стандартыг монгол хэлнээ хөрвүүлж, 51 баримт бичиг, 3 сургалтын хөтөлбөр боловсруулж, 800 гаруй ажилтныг сургахад дэмжлэг үзүүлээ.

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эрүүдэн шүүлтээс ангид байх, үл ялгаварлан гадуурхагдах зэрэг 12 сэдвээр НҮБ-ын хүний эрхийн механизмд мэдээлэл хүргүүлэхэд Хүний эрхийн ТББ-уудын Форумтай хамтран ажиллалаа.

- Шүүхийн үйл ажиллагааг шинэтгэлийн өмнөхтэй харьцуулах зорилгоор эрүүгийн хэргийн анхан шатны 4 шүүхэд хөндлөнгийн ажиглалт хийлээ.
- Улс төрийн санхүүжилтийн өнөөгийн тогтолцоонд дүн шинжилгээ хийж, улс төрийн намуудын санхүүжилтийн ил тод байдлыг олон улсын Кринис судалгааны арга зүйгээр үнэллээ.

ХҮНИЙ ЭРХ



Монголын Хүний эрхийн ТББ-уудын Форум НҮБ-ын ХЭЭ-д нийт 12 сэдвээр тайлан бэлтгэж хүргүүллээ.

Монгол Улс 1992 оны Үндсэн хуулиараа хүний эрх, эрх чөлөөг жинхэнэ утгаар нь баталгаажуулсны зэрэгцээ НҮБ-ын хүний эрхийн олон улсын гэрээ конвенцийг соёрхон батлах, нэгдэн орох чиглэлээр манлайлагч улсуудын нэг болсон билээ. Гэсэн хэдий ч төрийн албан хаагчид, нийт иргэдийн хүний эрхийн боловсрол нимгэн, хүний эрхэд суурилсан хандлага, арга зүй төрийн бодлого, үйл ажиллагаанд хэвшээгүй зэргээс үүдэн хүний эрхийн хэрэгжилтэд саад бэрхшээл учирч, зарим талаар олсон амжилтаасаа ухрах тохиолдол байна. ННФ нь байгуулагдсан үеэсээ эхлэн хүний эрхийн асуудлыг чухалчилж ирсэн бөгөөд 2014 онд (i) хүний эрхийг хамгаалах үндэсний механизмыг бэхжүүлэх, (ii) хүний эрхийн мэдлэг ойлголтыг түгээх, (iii) хүний эрхийн мониторинг, стратегийн өмгөөллийг дэмжих чиглэлээр дараах үйл ажиллагааг явуулж ирлээ.

Хүний эрхийг хамгаалах үндэсний механизмыг бэхжүүлэх

Хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавьж, зөрчигдсөн эрхийг нь сэргээн эдлүүлэхийн төлөө ажилладаг үндэсний механизм, тэр дундаа иргэний нийгмийн байгууллагын гүйцэтгэх үүргийг ННФ чухалчлан үзэж, тэдэнтэй хүний эрхийн асуудлаар хамтран ажиллаж, чадавхыг нь бэхжүүлэхэд гол анхаарлаа хандуулж байна. Энэ хүрээнд Монгол Улсын нэгдэн орсон гэрээ, Засгийн газрын үүрэг амлалтын биелэлтийг сайжруулах, хүний эрхийн хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр НҮБ-ын хүний эрхийн механизмтай хамтран ажиллаж буй

- Хүний эрхийн ТББ-уудын Форумаас илгээсэн мэдээллийг багцлан зургаан сэдвийн хүрээнд холбогдох төрийн байгууллагуудыг урьж, зөвлөлдөх уулзалт зохион байгууллаа. Зөвлөлдөх уулзалтыг хэвлэл мэдээллийн байгууллагууд ихээхэн сонирхож оролцсон бөгөөд 20 орчим хэвлэл мэдээллийн хэрэгслээр энэ тухай мэдээлэл цацагдлаа.

НҮБ-ын хүний эрхийн гэрээний хороодтой ажиллах чиглэлээр доорх үйл ажиллагааг явууллаа. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай конвенцийн Хороонд мэдээлэл бэлтгэн, хүргүүлэхэд туслалцаа үзүүлэв.
- Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооны гишүүнд газар албадан чөлөөлөх асуудлаар мэдээлэл хүргүүлэв.

ННФ-аас тавьж буй хүчин чармайлтын дүнд Хүний эрхийн ТББ-уудын Форумын үйл ажиллагаа төлөвшиж, хүний эрхийн тулгамдсан асуудлаар цаг тухайд нь төрийн байгууллагад хандсан нөлөөлөл явуулахаас гадна шаардлага

тавих болсныг тэмдэглүүштэй. Тухайлбал, зарим төрийн байгууллагад хүний эрхийн тулгамдаж буй асуудлаар албан захидал илгээж, асуулга хүргүүлэв. Үүнд:

- Хуулийн байгууллагын ажилтнуудын үйлдсэн хэрэг, зөрчлийг мөрдөн шалгах чиг үүрэг бүхий Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Мөрдөн байцаах албыг татан буулгасан шийдвэрийн мөрөөр УИХ-ын даргад асуулга хүргүүлэв.
- Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн 3-р зүйл буюу “эрүүдэн шүүж болзошгүй гэсэн бодит үндэслэл байвал хүнийг албадан гаргахгүй байх” гэсэн үүргийг сануулсан албан захидлыг ХЗЯ, Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газарт илгээв.
- Халдашгүй байх эрхийг хангаж, хүндэтгэж ажиллахыг хүссэн албан бичгийг ХЗЯ, УЕПГ, ЦЕГ-т хүргүүлэв.
- Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах асуудлаар ХЭҮК-т албан захидал хүргүүлэв.



Баруун гар талаас: Илтгэгч МУБИС-ийн багш Э. Гэрэлт-Од, “Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ” сэдвээрх өглөөний цай-уулзалтад оролцогчид, 2015 оны 2 дугаар сар.

Хүний эрхийн мэдлэг, ойлголтыг түгээх

ННФ хүний эрхийн хөтөлбөрийн хүрээндээ хүний эрхийг хөхиүлэн дэмжих, мэдлэг ойлголтыг түгээн дэлгэрүүлэх, тулгамдсан асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлэх зорилго бүхий олон нийтийн лекц, өглөөний цай-уулзалт, тавилттай уншлага зэрэг арга хэмжээг зохион байгуулж ирлээ. 2014 онд уул уурхай, хүүхэд хамгаалал, хүний эрхийн боловсрол, хүний эрхэм зэрэг, хүний эрхэд суурилсан эрүүгийн эрх зүй, хохирогчдын бодит хамгаалал зэрэг сэдвээр 6 удаа олон нийтийн лекц, уугуул иргэдийн эрх, мэдэх эрх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, газар албадан чөлөөлөлт зэрэг асуудлаар 10 удаагийн өглөөний цай-уулзалт болов. Хүний эрхийн мэдлэг, ойлголт түгээх хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны жагсаалт болон энэ сэдвийн хүрээнд шинээр бий болсон мэдээллийн дэлгэрэнгүйг үзэх вэб сайтуудын линкийг дараагийн хуудаснаас харна уу.

Зүүн хойд Азийн орнуудын UPR-ын зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр 2 жил тутамд зохион байгуулагддаг хуралдаанд оролцож Монголын туршлагаас хуваалцлаа. Хүний эрхийн ТББ-уудын Форумын UPR-ын зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагатай ажиллаж буй арга хэлбэр, нөлөөллийн үйл ажиллагааг тус бүс нутгийн иргэний нийгмийн байгууллагууд өндрөөр үнэлж, 2016 оны хуралдааныг Монгол Улсад хийх санаачилга гарлаа.

Түүнчлэн урлагаар дамжуулан хүний эрхийн мэдлэг, ойлголт түгээх, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхийг чухалчилж Глоб Интернэшнл Төв ТББ –аас санаачилсан “Театр хүний эрхийн төлөө” арга хэмжээг

дэмжиж ажиллалаа. ННФ уг арга хэмжээг Глоб Интернэшнл Төв, Авлигатай тэмцэх газар, Улсын драмын эрдмийн театрттай хамтран зохион байгуулж, авлига, ашиг сонирхлын зөрчил, хэвлэлийн эрх чөлөө, хүн худалдаалах гэмт хэрэг зэрэг сэдвээр бэлтгэсэн тавилттай уншлагыг олон нийтэд үзүүлсэн нь шинэлэг алхам болсон юм.



“Театр хүний эрхийн төлөө” арга хэмжээний хүрээнд болсон «Эцсийн шийдвэр» тавилттай уншлага
Зүүн гараас: УДЭТ-ын жүжигчин Б.Одончимэг, Н.Баярмаа
2014 оны 12 дугаар сарын 6.

**ХҮНИЙ ЭРХИЙН СЭДВЭЭР ЗОХИОГДСОН
ҮЙЛ АЖИЛЛАГАА**

I УЛИРАЛД

- ХҮНИЙ ЭРХИЙН ЛЕКЦ
Уул уурхай ба Хүний эрх (илтгэгч: Михайл Виндфурь, Германы Хүний эрхийн институтын Удирдах зөвлөлийн гишүүн, дэд дарга)
- ӨГЛӨӨНИЙ ЦАЙ-УУЛЗАЛТ
 - “Залуусын төлөө хэн, юу хийж байна вэ?”
 - “Уугуул хүмүүсийн эрх малчдад хамааралтай юу?”
 - “Газар чөлөөлөх үйл ажиллагаа ба Хүний эрх”

II УЛИРАЛД

- ХҮНИЙ ЭРХИЙН ЛЕКЦ
 - Бодит хамгаалал хуулийн шинэчлэл (илтгэгч: Д.Энхжаргал, Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн захирал)
 - Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал (илтгэгч: Б.Мөнхжаргал, Сургуулийн нийгмийн ажилтны холбооны тэргүүн)
- ӨГЛӨӨНИЙ ЦАЙ-УУЛЗАЛТ
 - “Иргэнд ээлтэй төрийн үйлчилгээ”
 - “Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ”

III УЛИРАЛД

- ХҮНИЙ ЭРХИЙН ЛЕКЦ
 - Хүний эрхийн боловсролыг чухалчлан үзэх нь (илтгэгч: Ч.Алтангэрэл, НҮБХХ-ийн “Хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавих үндэсний чадавхыг бэхжүүлэх нь” төслийн зохицуулагч)
 - Хүний эрхэд суурилсан эрүүгийн хууль тогтоомжийн шинэчлэл (илтгэгч: Г.Эрдэнэбат, Монгол Улсын Ерөнхий Прокурорын орлогч, Төрийн хууль цаазын шадар зөвлөх)
- ӨГЛӨӨНИЙ ЦАЙ-УУЛЗАЛТ
 - “Мэдэх эрх”
 - “НҮБ-ын ХЭЭ-д Хүний эрхийн ТББ-уудын Форумаас илгээсэн мэдээлэл”

IV УЛИРАЛД

- ХҮНИЙ ЭРХИЙН ЛЕКЦ
Хүний эрхэмсэг оршихуйг хамгаалах нь (илтгэгч: Б.Тэмүүлэн, МУИС-ХЗС-ийн захирал)
- ӨГЛӨӨНИЙ ЦАЙ-УУЛЗАЛТ
 - “Орон нутгийн төсвийн ил тод байдал”
 - “Чөлөөтэй илэрхийлэх нь хүний эрх”
 - “Туул гол-Өнөөгийн байдал”

**ХҮНИЙ ЭРХИЙН СЭДВЭЭР ГАРСАН
БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ДЭЛГЭРҮҮЛЖ ҮЗЭХ
ВЭБ САЙТЫН ХАЯГ**

**ХҮНИЙ ЭРХИЙН
ЦУВРАЛ ЛЕКЦ** www.mn-nhrc.org
www.forum.mn

**МЭДЭЭЛЛИЙН
ХУУДАС** www.forum.mn
www.upr-mongolia.mn

**БОГИНО
ХЭМЖЭЭНИЙ
ВИДЕО
НЭВТРҮҮЛЭГ** www.forum.mn

**ХҮНИЙ ЭРХИЙН
ТББ-УУДЫН
ФОРУМААС
ХИЙЖ БУЙ ҮЙЛ
АЖИЛЛАГАА,
БАРИМТ
МЭДЭЭЛЭЛ** www.upr-mongolia.mn

Хүний эрхийн мониторинг, стратегийн өмгөөллийг дэмжих

Хүний эрхийн зөрчлийг тогтоож, эрхийг хамгаалах нэг чухал арга хэрэгсэл бол стратегийн өмгөөлөл билээ. Тиймээс стратегийн өмгөөллийг Монголд хөгжүүлэх, эрх зүйн орчныг бүрдүүлэх, энэ чиглэлээр өмгөөлөгч, төрийн бус байгууллагын ажилтнуудыг чадавхжуулахад ННФ анхаарал хандуулж ажилладаг. Энэ онд ННФ-аас тэтгэлэг авсан “Нийтийн тээврийн хүртээмж”, “Дотуур байрны хүүхэд хамгаалал” сэдэвт стратегийн өмгөөллийн төсөл амжилттай хэрэгжиж дараах үр дүнд хүрлээ.

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийтийн тээврээр зорчих эрхийг хязгаарласан стандартыг хүчингүй болгуулав.
- Дотуур байрны хүүхэд хамгааллын асуудалд төрөөс анхаарал хандуулж, үндэсний хэмжээний суурь судалгаа хийхэд

нөлөөлөв. Мөн НҮБ-ын Хүүхдийн эрхийн хороонд дотуур байрны хүүхэд хамгааллын тулгамдсан асуудлаар мэдээлэл хүргүүлээд байна.

Түүнчлэн амжилттай болсон стратегийн өмгөөллийг танилцуулсан, тулгарч буй хүндрэл бэрхшээлийг дурдсан богино хэмжээний видео нэвтрүүлгүүд бэлтгэн олон нийтийн мэдээллийн хэрэгслээр цацлаа.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал нь манай улсад тулгамдсан асуудал бөгөөд ННФ-аас тэтгэлэг авсан Хүнс эвсэл, Глоб Интернэшнл төв ТББ нь “Цагаан будаа”-ны импортын зохицуулалт, хяналт, шалгалт, чанарт мониторинг хийлээ. Одоогоор мониторингийн үр дүнг боловсруулж байна.

СТРАТЕГИЙН ӨМГӨӨЛӨЛ: ХБИ - ИЙН НИЙТИЙН ТЭЭВРИЙН ХҮРТЭЭМЖ



Г. ГАНЗОРИГ
Монголын хараагүй иргэдийн үндэсний холбооны Залуучуудын зөвлөлийн дарга

Харааны бэрхшээлтэй хүн аль чиглэлийн автобус ирээд явж байгааг мэдэх ямар ч боломжгүй учир олон цаг хүлээж зогсдог. Уг нь буудал, чиглэлээ зарлачихдаг бол ямар ч асуудал гарахгүй.



Б. ЧУЛУУНДОЛГОР
Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбооны тэргүүн

Нийтийн тээвэр хүртээмж муу байгаагаас хөгжлийн бэрхшээлтэй иргэд чөлөөтэй зорчиж, нийгмийн амьдрал эрх тэгш оролцож чадахгүй байна. Энэ бол хүний эрхийн ноцтой зөрчил гэж би боддог.



Ц. ОЮУНБААТАР
Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үндэсний холбооны ерөнхийлөгч

Төр үүргээ биелүүлдэггүй. Шаардлагатай дүрэм, журам гаргахгүй, хууль зөрчсөн тохиолдолд хариуцлага ч тооцохгүй байна. Энэ тохиолдолд бид яах ёстой вэ? Бид жагсаал, цуглаан зохион байгуулж үзсэн. Үр дүнд хүрээгүй. Иймээс хуулийн хүрээнд СТРАТЕГИЙН ӨМГӨӨЛӨЛ хийе гэж шийдсэн.



Н. АРВИНТАРИА
Өмгөөлөгч

Стратегийн өмгөөллийн үр дүнд Стандартчилал, хэмжил зүйн газар нийтийн тээврийн үйлчилгээ, ангилал, түүнд тавигдах стандартад өөрчлөлт оруулахаар болсон. Цаашид ТББ-ууд гарсан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, шахаж шаардаж, бодит ажил болгох ёстой.

ХУУЛЬ САХИУЛАХ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

Монгол Улсад өрнөж буй хууль зүйн салбарын шинэчлэлд тодорхой хувь нэмэр оруулахыг зорьж ННФ бусад төрийн болон төрийн бус байгууллагуудтай үр дүнтэй хамтран ажиллаж ирлээ. Энэ хүрээнд Хууль зүйн яам (ХЗЯ)-тай байгуулсан санамж бичгийн дагуу шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх, шинээр батлагдсан Цагдаагийн албаны тухай хууль, Тахарын албаны тухай хууль, Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль, Төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль зүйн туслалцаа үзүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааны хүрээгээ тодорхойлж, хамтран ажиллалаа. 2014 онд хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааны стандартыг хүний эрхэд нийцүүлэн боловсруулах, шинэ тутам байгууллагыг бэхжүүлэх, алба хаагчдыг чадавхжуулах, тус салбарт иргэний нийгмийн байгууллагын мониторинг хийх ур чадварыг хөгжүүлэх, олон нийтэд шинэ хууль тогтоомж, зохицуулалтыг сурталчлахад дэмжлэг туслалцаа үзүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүллээ.

Хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааны стандартыг боловсруулах хүрээнд олон улсын цагдаагийн дарга нарын холбооноос гаргасан 101 жишиг баримт болон гэрч хохирогчийг хамгаалах, шүүхийн аюулгүй байдал зэрэг асуудлаарх олон улсын 8 жишиг баримт бичгийг монгол хэлнээ хөрвүүлж, Тахарын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газарт хүлээлгэн өгөөд байна. Эдгээр баримт

бичиг нь хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн, хангаж, хамгаалсан хууль сахиулах стандарт боловсруулахад чухал ач холбогдолтой эх сурвалж юм. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны стандартыг шинэчлэн гаргахад техникийн туслалцаа үзүүллээ. Энэ хүрээнд Олон улсын цагдаагийн дарга нарын холбооны журам стандартыг судалсны үндсэн дээр Монгол Улсын цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх боломжтой дүрэм, журмыг бэлтгэж, боловсруулав. Үүний зэрэгцээ Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм журам, баримт бичгүүдийг боловсруулахад зөвлөх үйлчилгээ үзүүлэв.

Мөн түүнчлэн Гэрч хохирогчийг хамгаалах үндэсний хөтөлбөрийн төслийг төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоотойгоор боловсруулж, ХЗЯ-д хүргүүлээд байна. Тахарын ерөнхий газар, Хууль зүйн туслалцааны төвийн чиг үүргийг шүүх, болон бусад хууль сахиулах байгууллагын чиг үүрэгтэй харьцуулсан дүн шинжилгээ хийлгэж, хүлээлгэн өгөв. Мөн шинээр үйл ажиллагаагаа эхэлсэн Тахарын ерөнхий газар, Хууль зүйн туслалцааны төв стратеги төлөвлөгөөгөө боловсруулахад нь дэмжлэг үзүүлж ажиллалаа. Иргэний зөвлөл ба олон нийтийн цагдаагийн дүрмийг боловсруулах явцад иргэд, төрийн бус байгууллагын оролцоог хангасан цуврал хэлэлцүүлэг зохион байгуулж, гарсан саналыг дүрэмд тусгасан эсэхэд анхаарч ажиллав. Үүний зэрэгцээ шинээр батлагдсан

хууль тогтоомж, хэрэгжүүлэх механизмыг олон нийтэд сурталчлан таниулах хэрэгцээ шаардлага их байна. Энэ хүрээнд Иргэний зөвлөл, олон нийтийн цагдаагийн үйл ажиллагааг олон нийтэд танилцуулсан шторк бэлтгэж, телевизүүдээр цацагдлаа. Шинээр бий болсон тогтолцоог дэмжих зорилгоор Ховд, Говь-Алтай, Булган, Говьсүмбэр аймгуудад нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын дэргэдэх Иргэний зөвлөлийн гишүүдэд зориулсан бүсчилсэн сургалт зохион байгуулав. Мөн Улаанбаатар хотын 9 дүүргийн нийт 190 олон нийтийн цагдаад зориулсан сургалтыг ЦЕГ-ын Сургалт дадлагын төвийг түшиглэн өнгөрсөн оны 8 дугаар сарын 4-27-ны өдрүүдэд зохион байгууллаа.

ХЗЯ-тай байгуулсан Санамж бичигт дурдсан нэг чухал зүйл бол тогтмол хяналт шинжилгээ хийж шинэчлэлийн үйл явцыг мэдээллээр хангах зорилт байв. Энэ хүрээнд хууль сахиулах үйл ажиллагаанд мониторинг хийх ТББ-ыг чадавхжуулах цуврал сургалт хийлээ. 2014 оны сүүлийн хагаст танхимын (84 цаг), танхимын бус (56 цаг), танилцах аялал (24 цаг), туршилтын мониторинг (45 хоног) гэсэн бүтэц бүхий, үе шаттай сургалтад нийт 21

ТББ-ыг хамрууллаа. Оролцогчид сургалтын төгсгөлд гурван багт хуваагдан оргон зайлсан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтныг эрэн сурвалжлах үйл ажиллагаа, иргэний зөвлөл байгуулагдах үйл явц, цагдаагийн байгууллагад ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт зэрэг асуудлаар туршилтын мониторинг хийж, үр дүнг хууль сахиулах байгууллагад танилцуулав. Уг туршилтын мониторинг нь танхимд олж авсан мэдлэгээ практикт ашиглан үр дүнг нь харах боломжийг оролцогчдод олгосноороо онцлогтой байв.

Мөн түүнчлэн хууль сахиулах байгууллагын чадавхыг бэхжүүлэх, шинээр байгуулагдсан Хууль зүйн туслалцааны төвийн ажилтнуудыг чадавхжуулах хүрээнд АНУ, ӨАБНУ руу дөрвөн хүнийг танилцах аялал, хурал семинарт оролцууллаа. Аюулгүй байдлын салбарын ил тод байдал, иргэний нийгмийн байгууллагын оролцооны тухай асуудлаар Дугуй ширээний ярилцлагыг Зэвсэгт хүчний салбар дахь ардчилсан хяналт олон улсын байгууллагатай хамтран зохион байгуулсан нь ихээхэн өгөөжтэй арга хэмжээ боллоо.

Хууль сахиулах байгууллагын ажилтнуудын сургалт, Нээлттэй Нийгэм Форум, 2015 оны 12 дугаар сар.



ХУУЛЬ САХИУЛАХ АЛБА ХААГЧДЫГ ЧАДАВХЖУУЛАХ ХҮРЭЭНД ХИЙГДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ХАМРАГДСАН БАЙГУУЛЛАГА

ЗОХИОГДСОН ҮЙЛ АЖИЛЛАГАА



- Цагдаагийн албаны тухай хуульд заасан дадлага, сургалтын төвийг бэхжүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэв.
- “Цагдаагийн алба хаагчийн ёс зүй, харилцаа, хандлага” сургалтын хөтөлбөр боловсруулав.
- Цаашид тус сургалтыг зохион байгуулах сургагч багш нарыг 3 хоногийн сургалтаар бэлтгэв. Сургалтад ЦЕГ-ын Дадлага сургалтын төвд бүртгэлтэй 31 сургагч хамрагдав.



- ТЕГ-ын нийт 9 тойргийн алба хаагчдад шинээр батлагдсан хууль тогтоомж, дүрэм журмыг таниулах сургалтыг тойрог тус бүрт зохион байгуулав. Сургалтад ТЕГ-ын хөдөө орон нутагт ажиллаж байгаа 340 алба хаагч хамрагдав.
- ТЕГ-ын алба хаагчдад зориулан “Мөрдөгч” сургалт зохион байгуулав.
- Шүүхийн хуяг бэлтгэх сургалтад ТЕГ-ын 35 алба хаагч хамрагдав.



- Хууль зүйн туслалцааны төвийн өмгөөлөгчдөд мэргэжлийн ур чадвар олгох сургалт зохион байгуулав. Тус сургалтад улсын 48 өмгөөлөгч, 10 өмгөөлөгчийн туслах, Хууль зүйн туслалцааны төвийн 2 ажилтан нийт 60 хүн хамрагдав.

ҮР ДҮН - ТООН ҮЗҮҮЛЭЛТЭЭР

- 19 төрлийн сургалтад 21 аймгийн цагдаа, тахар, улсын өмгөөлөгч, ТББ-ын нийт 807 хүнийг хамруулав.
- Хууль сахиулах ажиллагаанд мониторинг хийх чиглэлээр 21 ТББ-ын ажилтнуудыг чадавхжуулав.
- Хууль сахиулах салбарт хийсэн туршилтын 3 мониторингийн үр дүнг холбогдох байгууллагад танилцууллаа.
- Иргэний зөвлөл, олон нийтийн цагдааг иргэдэд танилцуулсан шторкууд бэлтгэж, цацав.
- Хууль сахиулах салбарт хамаарах олон улсын 109 жишиг баримт бичгийг монгол хэл рүү хөрвүүлэв.
- Чиг үүргийн дүн шинжилгээний 2 тайлан бэлтгэлээ.
- ТЕГ, ЦЕГ, ХЗТТ-ийн үйл ажиллагаанд мөрдөх 51 баримт бичиг боловсруулав.
- Иргэний зөвлөл, олон нийтийн цагдаа, цагдаагийн алба хаагчийн ёс зүй, харилцаа хандлагын асуудлаар нийт 3 сургалтын хөтөлбөр боловсруулав.

ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ

Монгол Улс 1990 онд ардчилсан нийгэмд шилжсэн үеэс эхлэн Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжоо шинэчлэх, шинээр боловсруулж батлах үйл явц өрнөсөн билээ. Эрх зүйн шинэчлэл хийхэд нэгдсэн бодлого, уялдаа холбоо шаардлагатай байсан тул 1998 - 2008 онд хэрэгжүүлэх Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийг УИХ-аас баталсан юм. Энэхүү хөтөлбөр хэрэгжиж дууссан тул үр дүнг үнэлж, шинээр хөтөлбөр боловсруулах талаар ярилцаж байгаа хэдий ч одоогоор тодорхой алхам хийгдээгүй байна. Харин Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрт эрх зүйн шинэчлэл хийх олон чухал зорилтыг дэвшүүлэн тавьсан юм. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар шүүх эрх мэдлийн шинэчлэл, иргэдийн бодит оролцоог баталгаажуулах чиглэлээр олон чухал хууль тогтоомж шинээр батлагдаж, парламентаар хэлэлцэгдэж байгаа билээ. Эдгээр алхмыг шүүх эрх мэдлийн болон хууль зүйн салбарын шинэчлэл, эрүүгийн эрх зүйн болон захиргааны эрх зүйн шинэтгэлийг хамарсан эрх зүйн шинэчлэлийн шинэ давалгаа гэж тодорхойлж болох юм.

ННФ нь эрх зүйн шинэчлэлийн хүрээнд шинээр боловсруулж буй хууль тогтоомжийн төсөл боловсруулах багт орж ажиллах, эрдэмтэн судлаачдаар бодлогын шинжилгээ хийлгэх, иргэд, иргэний нийгмийн байгууллагын дунд

хэлэлцүүлэг өрнүүлэх, гарсан санал шүүмжийг эмхэтгэн хууль тогтоогчдод хүргүүлэх зэргээр энэ үйл явцад санаачилга гарган ажиллаж байна. Санаачлан зохион байгуулж буй хуулийн хэлэлцүүлгүүд нь шинэчлэлийн үзэл баримтлалыг иргэний нийгмийн байгууллагад хүргэх, шинэчлэлийн явцад тэдний идэвхтэй оролцоог хангах, иргэний нийгмийн байгууллагаас гаргасан санал, зөвлөмжийг хууль тогтоогчдод хүргэх үр дүнтэй арга хэрэгсэл боллоо. Хуулийн хэлэлцүүлгээс гарсан үр дүнг эмхэтгэн “Хуулийн шүүмж” бэлтгэн хэвлүүлж, түгээж байгаа нь эрх зүйн шинэчлэлийн үр дүнг олон нийт, бодлого боловсруулагчдад хүргэхэд чухал ач холбогдолтой байлаа.

Зарим хуулийн хэлэлцүүлгийг УИХ-ын холбогдох байнгын хороо, УИХ-ын Тамгын газар, Хууль зүйн яам зэрэг төрийн байгууллагатай хамтран зохион байгуулсан нь үр дүнгээ өгч хэлэлцүүлгээс гарах санал, шүүмжид холбогдох талууд анхаарал хандуулах боломжийг бүрдүүлэв.

2014 онд эрх зүйн шинэчлэлийн хүрээнд хийгдсэн гол ажлыг дурдвал:

- Захиргааны ерөнхий хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай, Нийтийн сонсголын тухай хууль, Төрийн бус байгууллагын тухай, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх хууль,


тогтоомжийг хэрэгжүүлэх журмын тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт орж ажиллалаа.

- Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд боловсруулагдаж буй багц хуулийн төсөлд эрдэмтэн судлаачдын санал, шүүмжийг тусгахад дэмжлэг үзүүлээ.
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Хууль сахиулах үйл ажиллагааны тухай, Таслан сэргийлэх арга хэмжээний тухай,

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Гэмт хэргийн тухай, Зөрчлийн тухай, Нийтийн сонсголын тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг ТББ-уудын оролцоотойгоор зохион байгууллаа

- Нийт найман “Хуулийн шүүмж” боловсруулан хэвлэн бодлого боловсруулагчдад хүргэж, www.forum.mn цахим хуудсанд байршууллаа.

2014 ОНД ГАРСАН ХУУЛИЙН ШҮҮМЖ - ЦУВРАЛ



ШҮҮХИЙН ХАРААТ БУС БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ

Манай улсад шүүхийн нээлттэй, хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлэх зорилгоор 2012 онд батлагдсан шүүхийн шинэтгэлийн багц хууль 2013 оноос эхлэн хэрэгжиж байгаа билээ. ННФ энэхүү шинэтгэлийг дэмжин шинэ стратегийнхаа хүрээнд шүүхийн хараат бус

байдлыг бэхжүүлэхэд хувь нэмэр болох зорилгоор бодлогын судалгаа шинжилгээ, шүүхийн хөндлөнгийн ажиглалт хийх, олон талт хэлэлцүүлэг өрнүүлэх болон шүүхийн иргэдийн төлөөлөгчдийн бодит оролцоог дээшлүүлэх зэргээр холбогдох төрийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Шүүхийн шинэтгэл

Өнгөрсөн онд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээс шүүхийн тухай багц хуулийн зарим зүйл заалт Үндсэн хуульд харшилсан тухай шийдвэр гарсан нь иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс дээр дурдсан хуулиуд, тэдгээрийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ, дүн шинжилгээ хийх хэрэгцээ шаардлагыг

нэмэгдүүллээ. ННФ Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг шинжлэх, түүнийг мэргэжлийн хүрээнд авч хэлэлцдэг шинэлэг практик нэвтрүүлэх зорилгоор Цэцийн 2013 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн дунд суудлын хурлын дүгнэлтэд хийсэн эрх зүйн шинжилгээг танилцуулсан нь чухал алхам боллоо.



Зүүн гар талаас: “Үндсэн хуулийн цэцийн шийдвэрт дүн шинжилгээ хийх нь” шүүмж хэлэлцүүлэгт оролцогчид, Илтгэгч: Дэд профессор, доктор О.Мөнхсайхан, 2014 оны 7 дугаар сарын 1.



“Монгол Улс дахь шүүгчийн сонгон шалгаруулалт: Шүүгчид нэр дэвшигчийг үнэлэх ажиллагааг боловсронгуй болгох нь” сэдвээрх судалгааг судлаачид, мэргэжлийн оюутнуудад зориулан хэвлэж гаргалаа.

Эрх зүйн орчныг шинэчилснээр шүүхийн шинэтгэл бүрэн хийгдэнэ гэж үзэх нь учир дутагдалтай юм. Шинэтгэлийн явцад мониторинг үнэлгээ хийх, шинэтгэлийн үзэл санаа, туйлын зорилго нь хэрэгжилтийн явцад бүрэн утгаараа практикт бууж чадаж байгаа эсэхийг хянах нь түүний ач холбогдлыг бататгах болно. Форумын зүгээс Шүүхийн захиргаа, Шүүгчийн сонгон шалгаруулалт зэрэг тодорхой асуудалд эрх зүйч, судлаач нарыг татан оролцуулж мэргэжилтнүүд, энэ салбарт ажилладаг иргэний нийгмийн ажилтнуудын дунд хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Шүүхийн шинэтгэлийг үр нөлөөтэй явуулахад шударга, хараат бус шүүгчийн үйл ажиллагаа ихээхэн үүрэг гүйцэтгэнэ. Энэ агуулгаар ННФ “Монгол Улс дахь шүүгчийн сонгон шалгаруулалт: Шүүгчид нэр дэвшигчийг үнэлэх ажиллагааг боловсронгуй болгох нь” сэдвээр судалгаа захиалж, үр дүнг сонирхогч талуудын дунд хэлэлцүүлээ. Мөн энэхүү судалгааг хэвлэж салбарын мэргэжилтнүүдэд хүргэв.

Шүүхийн ажиглалт


Шүүхийн шинэтгэлийн үйл явц, үзэл санаа амьдралд хэрхэн нийцэж байгааг тандах зорилгоор ННФ 2014 оны сүүлээр “Шүүхийн ажиглалт” судалгааг хийж дуусгалаа. Ийм ажиглалтыг шүүхийн тухай багц хууль батлагдан гарахаас өмнөх үе буюу анх 2010 онд хийж байсан бөгөөд энэ удаа шинээр хэрэгжиж байгаа шүүхийн шинэтгэлийн явцыг тодорхой баримтад суурилан үнэлгээ хийх эхний алхам болов.

Энэ удаагийн шүүхийн ажиглалтыг 2010 онд хамрагдаж байсан Хөвсгөл, Дорнод аймаг дахь сум дундын шүүх, Дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны 1-р шүүхийг сонгон авч явуулсан нь шинэтгэлийн өмнө ба хойно гэсэн харьцуулсан дүн шинжилгээ хийх боломж олгосон юм.

Ажиглалтад МУИС-ийн ХЗС-ийн 10 оюутан, орон нутгийн иргэний нийгмийн 12 ажилтан таван өдрийн сургалтад хамрагдаж шүүхийн ажиглалтын арга зүйг эзэмшлээ.

ШҮҮХИЙН АЖИГЛАЛТЫН ДҮН

Нээлттэй шүүх хуралдаанд оролцох эрх хангагдсан байдал



Шүүх хуралдааны хойшлолт

2010 он		2015 он	
Нийт шүүх хуралдаан	Хойшилсон шүүх хуралдаан	Нийт шүүх хуралдаан	Хойшилсон шүүх хуралдаан
269	76	159	59
28.3%		37.1%	

Шүүх хуралдааны танхимын цэвэр, тохилог, хүндэтгэл төрүүлэхүйц байдал

Шүүхүүд	2015 он	2010 он
Дүүргийн эрүүгийн анхан шатны 1-р шүүх	93.3%	56.1%
Дорнод аймгийн шүүх	92.6%	80.0%
Хөвсгөл аймгийн шүүх	100%	100%
Төв аймгийн шүүх	100%	-

Доорх зурагт Шүүхийн ажиглалтын сургалтад хамтрагдсан ХЗС-ийн оюутнууд, ТББ-ын ажилтнууд. Сургагч багш ХЗС-ийн Практик сургалтын тэнхимийн эрхлэгч М.Туяа, ННФ-ын Засаглалын хөтөлбөрийн менежер П.Бадамрагчаа 2014 оны 11 сарын 27.



Шүүхийн иргэдийн төлөөлөгч

Форум нь шүүхийн иргэдийн төлөөлөгчийн оролцоог шүүхийн нээлттэй, хараат бус байдлыг хангах нэгэн чухал механизм гэж үзэн онцгой ач холбогдол өгч ирсэн билээ. Хэдийгээр Үндсэн хуулийн цэцээс шүүхийн иргэдийн төлөөлөгчдийн хэрэг хянан шийдвэрлэх эрхийг хүчингүйд тооцсон хэдий ч тэднийг сонгон шалгаруулж оролцуулах үндсэн ач холбогдол бүхий зохицуулалт хүчин төгөлдөр үйлчилж байна. 2014 оны 12 сарын байдлаар Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийг хэрэгжүүлж нийт 4700 гаруй иргэдийн төлөөлөгчийн нэр бүхий жагсаалтыг батлан нэгэнт сонгогдсон иргэдийн төлөөлөгч жилд нэг л удаа шүүх хуралд оролцох нөхцөлийг ханган ажиллаж эхлээд байна. Шүүхийн шинэтгэлийн олон нийтэд хандсан энэ чухал механизмыг хэрэгжүүлэхэд олон нийтийг мэдээллээр хангах, сонгогдсон иргэдийн төлөөлөгчдийг бэлтгэх, сургах зэрэг үйл

ажиллагааг үр нөлөөтэй хийж гүйцэтгэх нь өндөр ач холбогдолтой юм.

Цаашид иргэдийн төлөөлөгчийн оролцооны талаарх эрх зүйн боловсрол, мэдээллийг нэмэгдүүлэх болон хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох үйл ажиллагааг үе шаттайгаар авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Шүүх нээлттэй, хараат бус, шударга байх нь хүний шударгаар шүүлгэх эрхийн үндэс юм. Энэхүү эрхийн үндсэн агуулгыг тодорхойлж, олон улсын хэм хэмжээний хүрээнд тайлбарласан гарын авлагын хоёр дахь хэвлэлийг орчуулж хэвлэх, хүний эрхийн чиглэлээр ажилладаг болон шүүх, хуулийн байгууллагын ажилтнуудад хүргэх тэтгэлгийг Монголын Эмнести Интернэшнл байгууллагад олгоод байна.

**ШҮҮХИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИД
ТАВИГДАХ ШААРДЛАГА**

Монгол Улсын иргэн байх

25 нас хүрсэн байх

Эрх зүйн бүрэн чадамжтай байх

Ял шийтгүүлж байгаагүй байх

Монгол хэлээр чөлөөтэй ярьж ойлгодог байх



Тухайн анхан шатны шүүхийн харьяаллын нутаг дэвсгэрт байнга оршин суудаг байх

Сонгогдох үедээ эрүүгийн байцаан шийтгэх, иргэний болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэргийн оролцогч бус байх

Сүүлийн нэг жилийн хугацаанд иргэдийн төлөөлөгчөөр шүүх хуралдаанд оролцоогүй байх



ННФ-аас шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр сонгогдсон иргэдэд анхан шатны мэдээлэл олгох зорилгоор хялбаршуулсан гарын авлага бэлтгэн 10000 хувь хэвлэж анхан шатны бүх шүүхэд түгээлээ.

УЛС ТӨРИЙН САНХҮҮЖИЛТ

Улс төрийн санхүүжилт манай улсад Улс төрийн намын тухай хууль, УИХ-ын сонгуулийн хууль болон бусад хууль эрх зүйн актуудаар зохицуулагдаж байна. Холбогдох хууль эрх зүйн актууд шинэчлэгдэх бүрт улс төрийн санхүүжилтийн эрх зүйн орчин, санхүүжилтийн ил тод байдлын зарчмыг олон улсын жишигт ойртуулах алхам хийгдэж иржээ. Гэвч өнөөдөр улс төр болон бизнес, мөнгөний харилцааг нарийн тодорхой, ил тод байлгах эрх зүйн зохицуулалт, механизм дутагдсан хэвээр байна. Энэ нь сонгуулийн кампанит ажлын өртөг сонгуулиас сонгуулийн хооронд үлэмж өссөн¹; улс төрийн санхүүжилтийн хяналтгүй

тогтолцоо нь авлигыг нөхцөлдүүлэгч хүчин зүйлүүдийн нэг болж байгаа²; улс төрийн санхүүжилт ил тод бус байна гэж олон нийт дүгнэсэн³ зэргээс харагдаж байна.

Цаашид улс төрийн санхүүжилтийг ил тод болгон хяналт, хариуцлагын тогтолцоог сайжруулах, улмаар улс төрд үзүүлэх мөнгөний нөлөөг бууруулах нь өнөөгийн тулгамдсан асуудал болоод байгаа юм. Иймээс улс төрийн санхүүжилтийн асуудлыг ННФ 2014-2017 оны үйл ажиллагааныхаа стратегийн нэг сэдвээр сонгон ажиллаж тайлант хугацаанд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Улс төрийн санхүүжилтийн талаарх иргэдийн санал бодлын судалгаа

Энэ нь улс төрийн санхүүжилтийн талаар иргэдийн дунд явуулсан анхны судалгаа бөгөөд судалгааны дүнд тулгуурлаж бодлого боловсруулагчдад улс төрийн санхүүжилтийн ил тод байдал, өнөөгийн хууль эрх зүйн актын хэрэгжилт цаашдын чиг хандлагын талаарх иргэдийн төсөөллийг хүргэх зорилгоор

хийгдсэн болно. Уг судалгааг Сант Марал Сантай хамтран Улаанбаатар хот болон Говь-Алтай, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Ховд, Хөвсгөл аймгуудын нийт 1200 иргэнээс санал асуулга авч боловсрууллаа. Судалгааны дүнгээр иргэд улс төрийн санхүүжилт ил тод биш (67 хувь), сонгуулийн болон намын санхүүжилттэй

¹ <http://www.gec.gov.mn/details/827>

² http://www.iaac.mn/pdf/ssh/Report_CPPLS_2012_new.pdf

³ http://forum.mn/index.php?sel=project&menu_id=394&obj_id=5002

Улс төрийн санхүүжилтийн хууль эрх зүйн дүн шинжилгээ

Улс төр мөнгөнөөс их хамааралтай болох тутам түүнд үзүүлэх жирийн иргэдийн нөлөө багасдаг гэж үздэг. Өнөөдөр сонгуулийн кампанит ажлын зардлыг бууруулах, улс төрд үзүүлж буй мөнгөний нөлөөг бууруулах нь дэлхийн олон оронд тулгамдсан асуудал болсоор байна.

ННФ-аас улс төрийн санхүүжилтийн тогтолцоог ил тод, хяналттай, хариуцлагатай болгох, олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэх, манай улсын хууль эрх зүйн тогтолцоо, төрийн байгууламжийн онцлогт тулгуурлан оновчтой бодлого боловсруулах талаар судлан бодлогын дүн шинжилгээ хийснээс дурдвал:

- Монголын улс төрийн намуудын бүтэц, зохион байгуулалтыг иргэний оролцоог дэмжсэн, төлөөллийн ардчиллыг бэхжүүлэх

хөшүүрэг болох талаас нь харж илүү боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага байгааг МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн эрхлэгч, доктор, дэд профессор С.Мөнхбат ННФ-ын “Бодлогын асуудал” цувралын 13 дахь дугаарт нийтлүүлсэн судалгаа, шинжилгээгээрээ олон нийтэд хүргэв. Улс төрийн намын босоо бүтцэд шууд нөлөөлдөг санхүүжилтийн механизмыг өөрчилж, намын бодлого шийдвэр гаргах урсгал нь дээрээс бус дороос эхтэй байх зарчмыг нэвтрүүлэх талаар бодлогын зөвлөмжид тусгасан нь дотоод ардчилалтай намуудыг дэмжих эрх зүйн шинэтгэлийг эрэлхийлж байгаа өнөө үед цагаа олсон, ач холбогдолтой судалгаа боллоо.

УЛС ТӨРИЙН САНХҮҮЖИЛТЭЭР ГАРСАН “БОДЛОГЫН АСУУДАЛ” - ЦУВРАЛ



- Улс төрийн нам болгон санхүүгийн хувьд харилцан адилгүй нөөцтэй байгаа манай улсын хувьд намын үйл ажиллагаа, ялангуяа сонгуулийн сурталчилгааны зардлыг төрөөс тодорхой хэлбэрээр дэмжих нь намуудын том, жижгийн ялгааг багасгах, улмаар хоорондоо тэгш өрсөлдөх боломжийг бүрдүүлэхэд эерэг нөлөөтэй. Энэ асуудал шинээр ардчилалд шилжсэн, тэр дундаа пост-коммунист орнуудын улс төрийн намуудад илүү хамаатай болж байгаа хэдий ч тухайн улсын онцлог, төрийн байгууламжийн шинж чанарт тохируулж оновчтой зохицуулалт хийхгүй бол намууд иргэд сонгогчдоосоо хөндийрч, намын бие даасан байдал нь төрийн санхүүжилтээс хамааралтай болох зэрэг дутагдал гардаг. Энэ асуудлыг хөндөн улс төрийн намыг төрөөс санхүүжүүлэх талаар Доктор Ж.Төртогтох, судлаач Б.Эрдэндалай нар олон улсын нийтлэг жишиг хандлага, манай улсын онцлогт тулгуурлан дүн шинжилгээ хийж, бодлогын зөвлөмж боловсруулан “Бодлогын судалгаа” цувралын 14 дэх дугаарт хэвлэн нийтлүүлэв.
- Манай улсын өнөөгийн улс төрийн намын болон нэр дэвшигчдийн сонгуулийн тайлангаар санхүүжилтийн 90 орчим хувь нь хандиваас бүрддэг ажээ. Улс төрийн намын санхүүжилтийн эх үүсвэр болсон хандивын зохицуулалтыг илүү боловсронгуй болгон улс төрд тэгш, шударгаар өрсөлдөх боломжийг бүрдүүлэхийн тулд хууль эрх зүйн зохицуулалтад хандивын төрлийг, тухайлбал мөнгөн болон мөнгөн бус хандив, үйл ажиллагааны дэмжлэг зэргийг бүрэн дүүрэн хамруулж тодорхой тусгах; гуравдагч этгээдийг тодорхойлох; хандивын тайланг ил тод, олон нийтэд нээлттэй болгох талаар ННФ-ын менежер Б.Баттуул бодлогын зөвлөмж гарган “Бодлогын асуудал”-ын ээлжит цувралаар олон нийтэд хүргэлээ.

Улс төрийн намуудын санхүүжилтийн мониторинг

“Шударга сонгуулийн төлөөх иргэний нийгмийн байгууллагын түншлэл” сүлжээний үйл ажиллагааг дэмжих, өнөөгийн манай улс төрийн намын ил тод байдлыг тодорхойлох зорилгоор “Кринис” олон улсын судалгааны арга зүйгээр Монголын улс төрийн намуудын ил тод байдалд үнэлгээ хийлээ.

Уг судалгааг “Шударга сонгуулийн төлөөх иргэний нийгмийн байгууллагын түншлэл” сүлжээний гишүүд болох Глоб Интернэшнл, Сонгогчдын Боловсрол Төв, МИДАС, Өөрчлөлтийн төлөөх Залуу Эмэгтэйчүүд ТББ-ууд болон Транспэрэнси Интернэшнл олон улсын байгууллагын Монгол дахь салбартай хамтран 2012 онд УИХ-ын сонгуульд оролцохоор Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлсэн

улс төрийн намуудын санхүүжилтийн ил тод байдлыг үнэллээ. Кринисийн судалгаа нь улс төрийн намын дотоод нягтлан бодох бүртгэлээс гадна улс төрийн намын санхүүгийн тайланг хүлээн авдаг төрийн байгууллага болон судлаач, оюутан, иргэдийг хамруулан улс төрийн намын ил тод байдлыг дараах шалгуураар үнэлдэг ажээ. Үүнд:

- Намын санхүүгийн дотоод сахилга бат
- Сонгуулийн болон сонгуулийн бус үеийн тайлан
- Санхүүжилтийг олон нийтэд мэдээлж байгаа байдал
- Санхүүгийн тайлангийн бүтэц, нарийвчлал
- Тайлангийн үнэн бодит байдал

- Урьдчилан сэргийлэлт
- Хариуцлагын тогтолцоо
- Төрийн болон олон нийтийн хяналт зэрэг болно.

Судалгааны явцад улс төрийн намуудын санхүүжилтийн ил тод байдал нь хангалтгүй

дүнтэй гарсан бөгөөд улс төрийн намууд сонгуулийн болон сонгууль хоорондын санхүүжилтийн тайлангаа олон нийтэд ил тод болгох, гаргасан мэдээлэл нь хүртээмжтэй, байнга шинэчлэгддэг байх шаардлагатай зэрэг асуудлыг судалгааны дүнгээр онцоллоо.

Улс төрийн санхүүжилтийн тухай мэдлэг, мэдээлэл түгээх арга хэрэгсэл

СЭТГҮҮЛЧДИЙН КЛУБ: Улс төрийн санхүүжилтийн сэдвээр холбогдох мэдээ, мэдээллийг олон нийтэд тогтмол, үе шаттайгаар хүргэх, энэ сэдвээр сэтгүүлчдийн ойлголт, мэдлэгийг гүнзгийрүүлэх; улмаар улс төрийн санхүүжилтийн талаарх олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор сэтгүүлчдийн клуб байгуулан ажиллалаа. Уг клубийн идэвхтэн 10 орчим сэтгүүлч сард 1-2 удаа уулзаж хэлэлцэн улс төрийн санхүүжилтийн ил тод

байдал, хариуцлага, хяналтын тогтолцоо зэрэг сэдвээр асуудал хөндсөн мэдээ, нийтлэлээ олон нийтийн мэдээллийн хэрэгслээр гаргаж иргэд олон нийтийн ойлголт мэдлэгийг дээшлүүлэхэд анхааран ажиллаж ирлээ. Энэ нь улс төрийн санхүүжилтийн асуудал зөвхөн аль нэг нам, улс төрчийн асуудал бус олон нийт хяналт тавьж оролцох чухал асуудал юм гэсэн ойлголтыг нийгэмд түгээхэд ихээхэн хувь нэмэр оруулж байна.



Улс төрийн санхүүжилтийн асуудлаар мэдээ, сурвалжлага нийтэлдэг Сэтгүүлчдийн клубийн гишүүдэд Глоб Интернэшнл Төвийн тэргүүн Х.Наранжаргал мэдээлэл хийв. 2014 оны 12 дугаар сар.

ТӨРИЙН ИЛ ТОД, ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДАЛ

ХЭВЛЭЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг Үндсэн хуулиар болон Монгол Улсын нэгдэн орсон олон улсын бусад гэрээ хэлэлцээрээр хамгаалдаг билээ. Манай улсын нэгдэн орсон олон улсын гэрээ хэлэлцээр нь дотоодын хуулийн нэгэн адил хэрэгжих ёстойг Үндсэн хуульд заасан байдаг ч Засгийн газрын тогтоол, Харилцаа холбооны зохицуулах хорооны журам зэрэг захиргааны актаар зөрчих тохиолдол гарч байна.

Монгол Улсын Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулиар цензурын бүхий л хэлбэрийг хориглодог атал төрийн байгууллагууд хэвлэл мэдээллийн агуулгад хяналт тавьсан хэвээр байна. Нөгөө талаас улс төр, бизнесийн томоохон төлөөлөгчид хэвлэл мэдээллийн салбарт хөрөнгө оруулах нь сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэж, улмаар өөрийн эзэмшлийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг үзэл суртал, бизнесийн сурталчилгаа, нөлөөллийн хэрэгсэл болгон ашиглах хандлага түгээмэл болжээ.

ННФ нь Глоб Интернэшнл Төв ТББ-д 2012-2014 онд хараат бус хэвлэл мэдээллийн эрхийг дэмжих Хэвлэлийн эрх чөлөөний мониторинг төсөл хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэн ажиллаж ирлээ.

Глоб Интернэшнл Төвийн бүртгэснээр 2014 онд сэтгүүлчдийн мэргэжлийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх оролдлого хийх, дарамт шахалт үзүүлэх, сэтгүүлчдийг айлган сүрдүүлэх, мэдээлэл олж авах, түгээхэд нь саад учруулах, нууц эх сурвалжаа илчлэхийг албадах зөрчил нэмэгджээ. Түүнчлэн улс төрчид, төрийн байгууллага болон нийтийн албан тушаалтнууд Эрүүгийн хуулийн зүйл заалтыг сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгслийн дуу хоолойг боомилох цензур болгон ашиглах



явдал урд жилүүдтэй харьцуулахад нэмэгдсэн байна.

2013 онд 22 сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагатай холбоотой 35 зөрчил бүртгэгдэж байсан бол 2014 онд 33 сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын 57 зөрчил бүртгэгдэв. Эдгээрээс 21 буюу 64 хувь нь төрийн байгууллага, улс төрч, төрийн өндөр албан тушаалтан, төрийн албан хаагчдын зүгээс сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын эсрэг гаргасан мэргэжлийн эрхийн зөрчил байв.

Төрийн өндөр албан тушаалтны зүгээс сэтгүүлчийг нийтэлсэн мэдээллийнх нь төлөө хуулийн байгууллагад шалгуулах, дарамтлах, төрийн байгууллагаас хэвлэл мэдээллийн байгууллагад хууль бус цензур тавих явдал гарсаар байна. Мөн олон нийтийн сүлжээнд үзэл бодлоо илэрхийлснийх нь төлөө иргэнд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн зөрчил ч гарав. Зарим тохиолдлын жишээг доор харуулав.

2014 ОНД СЭТГҮҮЛЧ, ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГЫН МЭРГЭЖЛИЙН ЭРХИЙГ ЗӨРЧСӨН ЗАРИМ ТОХИОЛДОЛ

“Өглөөний сонин”-ы сэтгүүлч Р. Саруултөгс 2013 оны 5-р сард Герман Улсад суух Монголын элчин сайдын талаар асуудал хөндсөн нийтлэл бичжээ. Сэтгүүлчийг бусдыг гүтгэсэн, нэр хүндийг нь гутаан доромжилсон гэдэг үндэслэлээр Улсын мөрдөн байцаах газрын онц ноцтой хүнд гэмт хэрэгтэй тэмцэх тасаг шалгасан байна. Гэвч эрүүгийн хуулийн 111.2-т заасан бусдыг гүтгэх гэмт хэрэг нь онц хүнд гэмт хэрэг биш буюу тус тасгийн харьяалалд хамаарагддаггүй ажээ. Прокуророос мөрдөн байцаалтын явцад хэргийг 3 удаа хэрэгсэхгүй болгосон боловч тухай бүрт Улсын Ерөнхий Прокуророос хэргийг сэргээн өөр прокурор томилон шалгуулсан байна. Жил гаруй хугацаанд хуулийн байгууллагад дуудагдан шалгагдсаны эцэст 2014 оны 7 дугаар сарын 29-нд сэтгүүлч Р. Саруултөгсийн хэрэг Дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхэд таслан шийдвэрлэгдэж түүнийг цагаатгажээ.

2014 оны 7 дугаар сарын 3-ны өдөр www.amjilt.com цахим хуудсын сэтгүүлч гэрэл зураг бүхий баримтад тулгуурлан “Ерөнхий сайдын “Хаан жимс” амралтын газар Туул гол руу бохироо асгаж байна” гарчигтай нийтлэл бичжээ. Тус нийтлэл гарсны маргааш буюу 7 дугаар сарын 4-ний өдөр Харилцаа Холбооны Зохицуулах Хороо (ХХЗХ)-ны холбогдох албан тушаалтан тус цахим хуудсын удирдлага руу утасдаж “Хаан жимс” амралтын газар гомдол гаргасан тул нийтлэлээ устгаж залруулга гаргахыг шаардаж, цахим хуудсыг хаахаар сүрдүүлсэн байна. Энэ ярианаас хойш 3 цагийн дараа тус сайтыг ХХЗХ-ны хар жагсаалтад бүртгэн хаажээ. www.amjilt.com ХХЗХ-г хариуцагчаар татан захиргааны хэргийн шүүхэд хандан гомдол гаргасан бөгөөд гурван шатны шүүхээс тус цахим хуудсыг үндэслэлгүй хаасан болохыг тогтоожээ.

2014 оны 8 дугаар сарын 18-нд Дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхээс Ц.Батыг Зам тээврийн сайд А.Гансүхийн нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор олон нийтэд илт худал гүтгэлэг тараасан гэмт хэрэг үйлдсэн гэж тооцож, Эрүүгийн хуулийн 111.2 дугаар зүйлийн дагуу гурван сар 10 хоногийн хугацаагаар баривчлах ялаар шийтгэжээ. Жиргээч Ц.Бат инженерийн “хэрэг”-ийг найман сарын хугацаанд шалгасан гэх бөгөөд түүнийг сайдын нэр төрд халдаж жиргэсэн хэмээн шүүх буруутгажээ. Үр дүнд нь жиргээч Ц.Бат 22 хоног хоригдсон байна.

БАЙГАЛЬ ОРЧНЫ ТАЛААР МЭДЭЭЛЭЛ АВАХ ИРГЭДИЙН ЭРХИЙГ БАТАЛГААЖУУЛАХ НЬ

Эрүүл, аюулгүй орчинд амьдрах нь хүний амьдрал явах эрхтэй салшгүй холбоотой билээ. Энэхүү эрхээ бодитоор эдлэхэд байгаль орчны мэдээлэл чухал үүрэгтэй. Засгийн газар байгаль орчны асуудлаар шийдвэр гаргахдаа олон нийтийн оролцоог хангаж, мэдээлэл ил тод болгохоос гадна байгаль орчинд гэм хор учирсан тохиолдолд үр дүнтэйгээр нөхөн сэргээх зэрэг нэмэлт үүрэг хүлээх шаардлага тулгарч байна.

Дэлхийн нөөцийн хүрээлэн, Нээлттэй нийгэм сангуудын Хүний Эрхийн Санаачилга хөтөлбөрийн хүрээнд эхэлсэн “Байгаль орчны талаар мэдээлэл авах иргэдийн эрхийг баталгаажуулах нь” төсөл 2 дахь жилдээ үргэлжилж байгаа бөгөөд Нээлттэй Нийгэм Форум ерөнхий зохицуулагчаар нь ажиллаж ирлээ. Уг төсөл (STRIFE-II: Strengthening the Right to Information for People and the Environment) 2014-2015 онд Монгол болон Индонез улсуудад хэрэгжиж байгаа юм. 2013 онд Индонез Улсын туршлагыг судалсан Монголын иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл 2014 онд (i) байгаль орчны мэдээллийн ил тод байдал, хүртээмжийг тодорхойлох, (ii) Туул голын сав газарт байгаль орчны мэдээллийг ил тод болгох загвар төслийг хэрэгжүүлэн үр дүнг нь гаргаад байна.

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ХҮРТЭЭМЖИЙГ ТОДОРХОЙЛОХ:

Энэхүү судалгааны хүрээнд Хүний эрх хөгжил төв Монгол Улсын байгаль орчны ардчиллын индексийг тодорхойлох, усны чанарын тухай мэдээллийн индикатор боловсруулах, байгаль орчны мэдээллийн сангийн бүтэц, агуулга, мэдээллийн ойлгомжтой байдлыг шинжлэх багц ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- Монгол Улсын байгаль орчны ардчиллын индексийг (i) мэдээлэл олж авах, (ii) мэдээлэлд түшиглэсэн иргэдийн оролцоо, (iii) зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр шүүхэд хандах боломж гэсэн гурван үндсэн үзүүлэлтээр үнэлж тодорхойллоо. Энэ индексийг Дэлхийн нөөцийн хүрээлэнгийн боловсруулсан арга зүйгээр тодорхойлсон болно. Монголын Улсын хувьд байгаль орчны мэдээллийг ил болгох тухай хууль эрх зүйн тодорхой зохицуулалт байдаг хэдий ч тэдгээр зохицуулалт нь оновчгүй, үр нөлөө багатай байна. Иймээс нийт судалсан хууль тогтоомжийн 65 хувийг өөрчлөн сайжруулах шаардлагатай гэсэн судалгааны дүн гарчээ. Шийдвэр гаргах явцад иргэдийн оролцоог хангасан эрх зүйн зохицуулалт хангалтгүй

БАЙГАЛЬ ОРЧНЫ АРДЧИЛЛЫН ИНДЕКС

Байгаль орчны ардчиллын индекс (БоАИ) нь улс орнууд иргэддээ байгаль орчны холбогдолтой мэдээлэл өгөх, шийдвэр гаргах процесст оролцуулах, шүүхэд нэхэмжлэл гаргах эрх олгох, мөн энэхүү эрхийг нь хамгаалах чиглэлээр хэрэгжиж буй хууль тогтоомжийн чанарыг хэмждэг үзүүлэлт юм. Дэлгэрэнгүй мэдээллийг доорх линкээс үзнэ үү.
<http://www.wri.org/our-work/project/access-initiative-tai/commissions>

буюу 13 хувьтай байгаа нь иргэд мэдээлэлтэй байх, улмаар тэрхүү мэдээлэлдээ тулгуурлан амьдралд нь нөлөөлөх чухал шийдвэр гаргах явцад оролцох боломж хомс байна гэж дүгнэж болно. Төрийн байгууллагын зүгээс мэдээлэл авах эрхийг зөрчсөн тохиолдолд шүүхэд нэхэмжлэл гаргах, эрхээ сэргээлгэх эрх зүйн боломж 46 хувьтай байгаа нь хангалтгүй үзүүлэлт юм.

- Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам (БОНХАЖЯ)-ны Байгаль орчны мэдээллийн сангийн бүтэц, агуулга, мэдээллийн ойлгомжтой байдалд дүн шинжилгээ хийхэд хуулиараа олон нийтэд нээлттэй байх мэдээлэл ч уг мэдээллийн санд ороогүй буюу нийтэд ил тод биш байв. БОНХАЖЯ-наас мэдээллийн сангаа шинэчлэх ажлыг эхлүүлсэн бөгөөд STRIPE II төслийн зүгээс хийсэн судалгаа, үнэлгээний тайланд тулгуурлан шаардлагатай нөлөөллийн ажил хийхээр төлөвлөж байна.

- Усны чанарын тухай мэдээллийн индикаторыг боловсруулахдаа Монгол Улсын хууль; ус, хүрээлэн буй орчны хамгаалал, хаягдалтай холбоотой стандартууд; холбогдох дүрэм журмыг харьцуулан судалжээ. Үүнээс гадна усны чанарын талаар холбогдох мэдээллийг олон нийтэд хүргэх үүрэг бүхий байгууллагуудыг тодорхойлов. Үүнд, БОНХАЖЯ, Байгаль орчны мэдээллийн төв, Хот суурин газрын усан хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл, Стандартчилал хэмжил зүйн үндэсний төв, Ус, цаг уур орчны хүрээлэнгийн Ус судлалын сектор, Усны үндэсний хороо, Ашигт малтмалын газар, Сав газрын зөвлөл; Аймаг нийслэлийн байгаль орчны алба, Уул уурхайн яам, Усны хяналт шинжилгээний сүлжээ, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Байгаль орчны хяналт шинжилгээний сүлжээ, аймаг, нийслэлийн байгаль орчны албад зэрэг төрийн байгууллагыг тодорхойлж индикаторын дагуу үнэлгээ хийсэн байна.



Дээрх байгууллагууд усны чанарын талаар иргэдэд хэрэгцээтэй мэдээллийг хангалттай хэмжээнд боловсруулж гаргадаггүй, ил гаргасан мэдээллээ шинэчилдэггүй байна. Усны чанарын тухай мэдээллийн индикаторын үнэлгээгээр усны чанарын тухай мэдээллийн 50 орчим хувь нь ил болоогүй байгаа нь тун хангалтгүй, олон улсын жишиг үзүүлэлтээс маш доогуур байгааг харуулж байна. Иймд байгаль орчны тэнцвэртэй байдал, иргэдийнхээ эрүүл аюулгүй амьдрах эрхийг хангаж, хэрэгжүүлэхийн тулд холбогдох хуулиудад шаардлагатай өөрчлөлт оруулж, хэрэгжилтийг сайжруулахад анхаарч ажиллах нь нэн чухал байна.

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭДЭЭЛЛИЙГ ИЛ ТОД БОЛГОХ ЗАГВАР ТӨСӨЛ: Энэ төслийг Хөвсгөл Далайн Эзэд ТББ Туул голын орчны бохирдлын нөлөөнд амьдарч буй Хан-Уул дүүргийн 13-р хороо болон Төв аймгийн Заамар сумын Хайлааст багийн иргэдтэй хамтран хэрэгжүүллээ. Энэ бүс нутагт Улаанбаатар хотын төвлөрсөн цэвэрлэх байгууламж; түгээмэл тархацтай ашигт малтмалын орд; алтны шороон болон үндсэн орд газар; гахай, тахианы аж ахуй эрхэлдэг зэргээс хамаараад агаар, усны бохирдол их байдаг ажээ.

Төслийн хүрээнд Туул голын усны ашиглалт, бохирдлын талаар мэдээлэл цуглуулах, холбогдох байгууллагуудаас ирүүлсэн мэдээллийг үнэлэх, иргэдэд мэдээллийг энгийн ойлгомжтой хэлбэрээр боловсруулан боломжит арга хэрэгслээр хүргэх, байгаль орчны мэдээллийн www.baigaliorchin.mn цахим хуудас, олон нийтийн мэдээллийн сүлжээ (твиттер, фейсбүүк)-гээр байгаль орчны мэдээллийг иргэдэд хүргэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэв.

Иргэд Туул гол уруу бохир усаа асгадаг аж ахуйн нэгж байгууллага (ААНБ)-ын тоо, эзэмшигчдийн нэрс, элс, хайрга олборлож буй ААНБ-ын тусгай зөвшөөрөл, кадастрын зураг, эдгээр ААНБ-ын үйл ажиллагаатай холбогдох байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайлан, төрийн байгууллагуудаас хийсэн хяналт, шалгалтын дүн, агаарын болон усны чанарын шинжилгээний дүн, цэвэрлэх байгууламжийн хүчин чадал, цэвэрлэгээний чанар, Хан-Уул дүүргийн 13-р хороо, Төв аймгийн Заамар сумын Хайлааст багийн нутаг дэвсгэрт харьяалагдах Туул голын усны боломжит нөөц, найрлага, чанар, малын өвчлөлийн мэдээ, голын бохирдол оршин суугчдын эрүүл мэндэд хэрхэн нөлөөлж байгаа талаарх судалгаа, үр дүн зэрэг амьдарч буй орчныхоо бохирдлын талаар мэдээлэл авахыг хүсч төрийн байгууллагад өргөдөл гаргасан.

Эдгээр өргөдлийн ихэнхэд ямар нэг хариу өгөөгүй ба цөөн тохиолдолд “мэдээлэл өгөхгүй, нууц”, “мэдээлэл хүссэн шалтгаанаа хэлбэл өгнө” гэх хариулт хэлжээ.



Хайрга олборлолт, үйлдвэрийн болон цэвэрлэх байгууламжийн хаягдлаар бохирдсон Туул голоос мал, амьтан ууж, бүтээгдэхүүнийг нь хэрэглэдэг иргэдэд ус, агаар, хүнсний бохирдлоос эрүүл мэндээрээ хохирох аюул тулгарч байна. ХУД-ийн 13-р хорооны нутаг дэвсгэрийн Туул голын эрэг, 2014 оны 10 дугаар сар.

Энэ нь мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуулийн ноцтой зөрчил бөгөөд цаашид дээд шатны байгууллагад гомдол гаргах зэрэг дараагийн үйл ажиллагааг хуулийн хүрээнд авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Төслийн явцад орон нутгийн иргэд, амьдарч буй газрынхаа байгаль орчны төрх байдал, бохирдлын түвшин, эдгээр нь тэдний эрүүл мэнд, амьдрал ахуйд хэрхэн нөлөөлж байгаа талаарх мэдээллийг авах хүсэлтэй байдаг нь тод харагдлаа. Өнөөдрийг хүртэл иргэдийн хувьд хүрээлэн байгаа орчных нь тэр дундаа тухайн баг хорооны нутаг дэвсгэрт ашигт малтмал олборлож байгаа аж ахуйн нэгж, байгууллага болон орчны агаар, усыг бохирдуулж буй үйлдвэр, үйлчилгээний газрын талаарх мэдээлэл

туйлын хомс, мэдээлэл байсан ч түүнийг хаанаас, хэрхэн авах талаар тодорхой ойлголт, мэдээлэл иргэдэд байхгүй байв.

Байгаль орчны талаар мэдээлэл авах иргэдийн эрхийг баталгаажуулах төслийн хүрээнд хийгдэх дараагийн ажил нь дээр дурдсан суурь судалгаанууд, туршилтын төслийн үр дүнд тулгуурлан байгаль орчны мэдээллийн стандарт буюу байгаль орчны ямар төрлийн мэдээллийг хэрхэн ил болгох талаар бодлогын баримт бичиг боловсруулж батлуулах явдал юм. Мөн өмнөх хоёр шатны үр дүнг олон нийт, бодлого боловсруулагчдад хүргэх, нөлөөллийн ажлыг өргөн хүрээнд явуулж эхэлсэн бөгөөд ННФ Дэлхийн нөөцийн хүрээлэнтэй хамтран тус төслийн үйл ажиллагааг 2015-2017 онд үргэлжлүүлэн дэмжих болно.



ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ МЕХАНИЗМ

ННФ-ын 2014-2017 оны стратегид тусгасан “Хариуцлагатай байдлыг бэхжүүлэх механизм” санаачилгын доор төрийн ил тод, хариуцлагатай байдлын эрх зүйн орчныг сайжруулах зорилго дэвшүүлсэн билээ. Энэ хүрээнд 2014 онд авлига болон ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх, төрийн албаны ил тод байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийн тогтолцоог боловсронгуй болгох асуудалд холбогдох байгууллагуудын анхаарлыг хандуулах, энэ талаарх олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа хэрэгжүүлсэн юм. Тухайлбал, манай улсад үйлчилж байгаа хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийн тогтолцоонд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр энэхүү тогтолцооны үндсэн үүрэг болох ашиг сонирхлын зөрчил, авлигаас урьдчилан сэргийлэх үүргийг хэрхэн бэхжүүлэх тухай Зөвлөмж боловсруулж олон нийтэд хүргэлээ.

Хэдийгээр төрийн албан тушаалтнуудын хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газраас жил бүр хянан шалгадаг ч хамруулж буй мэдүүлгийн тоо нь нийт мэдүүлгийн 0.7-1 хувьтай тэнцдэг ажээ. Үүнээс гадна тухайн онд мэдүүлгээ шалгуулсан албан тушаалтан дараа жилд нь дахин шалгуулах магадлал бараг үгүй тул нийтийн албан тушаалтнууд авлига авах, хувийн ашиг сонирхлоо нийтийнхээс дээгүүр тавих, мөн энэ талаар үнэн зөв мэдүүлэхгүй байх эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Иймээс ННФ-аас Авлигатай тэмцэх газар болон холбогдох бусад байгууллагад мэдүүлгийг

random audit буюу санамсаргүй түүврээр сонгож шалгах аргыг нэвтрүүлэх талаар Зөвлөмжид тусгаж хүргүүлэв. Энэхүү арга нь хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийн тогтолцооны голлох үүрэг болох авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үүргийг бэхжүүлэхэд хамгийн үр дүнтэй болохыг олон улсын сайн туршлага харуулсан юм.

ХӨРӨНГӨ ОРЛОГЫН МЭДҮҮЛГЭЭР ГАРСАН БОДЛОГЫН ШИНЖИЛГЭЭ



2012 онд 316, 2013 онд 557 мэдүүлгийн агуулгыг шалгасан бөгөөд энэ нь тухайн жил бүртгэж авсан нийт 47000 орчим мэдүүлгийн зөвхөн 0.7-1 хувьтай тэнцэхүйц үзүүлэлт юм.

Форум 2014 онд нийтийн албан дахь хувийн ашиг сонирхлын зохицуулалтын эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр хийсэн дээрх судалгаа, шинжилгээнээс гадна нийтийн албаны ил тод, хариуцлагатай байдлын механизмын хэрэгжилтэд хяналт тавих иргэний нийгмийн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх зорилгоор энэ

чиглэлийн мониторингийг дэмжиж ажиллалаа. 2012 онд батлагдсан Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7, 8, 9-р зүйлийн хэрэгжилтэд Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн ТББ ННФ-ын санхүүгийн дэмжлэгтэйгээр мониторинг хийлээ. Мониторингоор ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн байгууллагуудад зохион байгуулж буй ажил, нийтийн албан тушаалтнуудын зүгээс ашиг сонирхлын зөрчлийг мэдэгдэх, тайлбарлах, мөн албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдлыг мэдэгдэх зэрэг дээр дурдсан хуулийн зүйл, заалтуудын хэрэгжилт хангалтгүй эсхүл огт хэрэгжихгүй байгааг тогтоосон юм.

Иймээс дээр дурдсан хуулийн зүйл заалтад нэмэлт, өөрчлөлт оруулж, хэрэгжилтийг сайжруулах талаар Зөвлөмж боловсруулан Авлигатай тэмцэх газар, УИХ-ын Авлигын эсрэг албан бус бүлэг болон холбогдох төрийн байгууллагуудад хүргүүлээ.

Үр дүнд нь Авлигатай тэмцэх газраас Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийхээ мэдэгдэж, үнэлгээнд мониторингийн дүнг мөн ашиглахаа илэрхийллээ.

АШИГ СОНИРХЛЫН ЗОХИЦУУЛАЛТЫН ЭРХ
ЗҮЙН ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ



Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7, 8, 9-р зүйлийн хэрэгжилтэд Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн ТББ мониторинг хийж үр дүнг нь хэвлэн гаргалаа.

ИРГЭНИЙ НИЙГМИЙН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ

Монголын иргэний нийгмийн байгууллагууд өнгөрсөн хугацаанд ардчилсан засаглалыг бэхжүүлэх чиглэлээр олон чухал үйл ажиллагаа хэрэгжүүлж, багагүй амжилтад хүрсэн билээ. Хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлэх, нийгмийн хөгжил, шийдвэр гаргах үйл явц дахь иргэдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр сургалт, судалгаа, хяналт мониторинг, нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах, бодлогын нөлөөлөл зэрэг үйл ажиллагааг нийгмийн бүхий л салбарт хэрэгжүүлж, улс орны хөгжилд бодитой хувь нэмэр оруулсаар байна. Энэ

амжилтыг улам баталгаажуулах үүднээс иргэний нийгмийн чадавхыг бэхжүүлж, авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааг нь дэмжих чиглэлээр ННФ байнга анхаарч ирлээ. 2014 онд иргэний нийгмийн байгууллагын чадавхыг бэхжүүлэхэд тодорхой зорилго бүхий мониторинг, бодлогын болон бусад төрлийн судалгааны тэтгэлэг олгож дэмжих үйл ажиллагаагаа үргэлжлүүлснээс гадна иргэний нийгмийн байгууллагын институцийн хөгжлийг дэмжих хөтөлбөр шинээр хэрэгжүүлж эхэлсэн нь онцлог байлаа.

Мониторинг

Төр, орон нутгийн байгууллагаас хариуцлага шаардах, төрийн үйл ажиллагаа, үйлчилгээний чанар, хүртээмжид мониторинг хийх хүрээнд нийт 23 байгууллагад тэтгэлэг олгов. Сум хөгжүүлэх сан болон Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зарцуулалт, ил тод байдал,

иргэдийн оролцооны чиглэлээр 12, төрийн ил тод, хариуцлагатай байдлын чиглэлээр 6, уул уурхай, газрын тосны салбарын хууль тогтоомж, гэрээний хэрэгжилтийг хянах чиглэлээр 5 байгууллагын үйл ажиллагааг дэмжин ажиллаж байна.



Мониторингийн төсөл хэрэгжүүлэхээр тэтгэлэгт шалгарсан ТББ-уудын ажилтнууд арга зүйн сургалтад хамрагдав. 2014 оны 12 дугаар сарын 4-5.

Түүнчлэн хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагаанд мониторинг хийх арга зүйн сургалт зохион байгуулж, туршилтын мониторинг хэрэгжүүлж эхэлсэн нь энэ чиглэлээрх иргэний нийгмийн чадавхыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулав.

Мониторингийн тэтгэлэгт хамрагдсан төрийн бус байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх арга зүйн сургалтад төслийн багууд бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцож, сайн засаглалыг төлөвшүүлэхэд иргэний нийгмийн гүйцэтгэх үүрэг, түүнд мониторингийн арга хэрэгслийг

ашиглах, мониторингийн зорилго, зорилтыг оновчтой тодорхойлж, үйл ажиллагаагаа төлөвлөх, мэдээлэл цуглуулах, судалгааны аргуудыг ашиглах, нөлөөлөл хийх зэрэг мониторингийн үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд шаардагдах ойлголт мэдлэгийг олж авлаа. Түүнчлэн өмнө нь мониторингийн төсөл амжилттай хэрэгжүүлсэн байгууллагууд туршлагаа хуваалцсан нь төслийн багийнханд практик дадлага олгосон ач холбогдолтой ажил болсон юм.

Иргэний нийгмийн байгууллагуудын институцийн хөгжлийг дэмжих

Монголын иргэний нийгмийн байгууллагын санхүүжилтийн нэлээд хэсгийг олон улсын донор байгууллагуудаас олгож буй санхүүгийн дэмжлэг эзэлдэг. Харин төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага гэрээгээр гүйцэтгэх боломжтой болсон явдал нь зарим байгууллагын санхүүжилтэд тодорхой хувь нэмэр оруулж байна. Гэхдээ дээрх санхүүжилтийн хэлбэрүүд нь дангаараа иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагаа болон санхүүгийн тогтвортой байдлыг хангаж чадахгүй байгаа юм. Иймээс иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагааны таатай орчныг бүрдүүлэх, ажилтнуудыг чадавхжуулах зэрэг нь тулгамдсан асуудал хэвээр байна. Иргэний нийгмийн байгууллагад тогтмол санхүүжилт байхгүй, татварын ээлтэй орчин бүрдээгүй зэргээс үйл ажиллагаа нь зөвхөн төсөл, хөтөлбөр зэргээр хязгаарлагдаж, тодорхой асуудлаар тогтвортой мэргэшин ажиллах боломж бүрдэхгүй байгаа юм. Иймд ННФ нь 2014 оноос иргэний нийгмийн институцийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлээд байна. Энэ хөтөлбөрийн хүрээнд төрийн бус байгууллагын мэдээллийн нэгдсэн сан үүсгэн (www.cso.mn), тогтвортой ажиллаж

амжилт ололтод хүрсэн үйл ажиллагааны үр дүнг харуулсан цуврал видео нийтлэл бэлдэж олон нийтийн мэдээллийн хэрэгслээр гаргалаа. Мөн байгууллагын тогтвортой хөгжлийн стратеги боловсруулах тэтгэлэг олгон, арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

ТББ-ЫН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН: Монгол Улсад албан ёсны бүртгэлтэй бүх төрийн бус байгууллагын хаяг, байршил, үйл ажиллагааны чиглэл, зорилго зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан www.cso.mn цахим хуудас үүсгэн ажиллуулж байна. Энэхүү цахим хуудсаар дамжуулан гадаад, дотоодын байгууллага, иргэд Монголын иргэний нийгмийн байгууллагуудын тухай цогц мэдээллийг нэг дороос авах болон иргэний нийгмийн байгууллагууд мэдээллээ өөр хоорондоо шуурхай солилцон хамтран ажиллах боломж бүрдээд байна.

БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ БОЛОВСРУУЛАХ ТЭТГЭЛЭГ: 2014 онд бид тогтвортой үйл ажиллагаа, үр нөлөөгөөрөө нийгэмд танигдсан 11 төрийн бус байгууллагад институцийн хөгжлийг дэмжих тэтгэлэг олголоо. Энэ хүрээнд байгууллагын үйл ажиллагаа

болон санхүүгийн тогтвортой байдлыг хадгалах талаарх БНСУ-ын иргэний нийгмийн байгууллагуудын туршлагаас суралцах 5 хоногийн аялал зохион байгууллаа. Аялалд үйл ажиллагаагаараа нийгэмд танигдсан 11 төрийн бус байгууллагын төлөөлөл оролцсон бөгөөд БНСУ-ын 10 төрийн бус байгууллагад зочлон тэдний үйл ажиллагаа, байгууллагын хөгжлийн стратегитай танилцаж, харилцан туршлага судаллаа.

Туршлага судлах аяллаар танилцсан ардчиллыг бэхжүүлэх, хүний эрхийг хамгаалах, нийгмийн шударга ёсыг хангахад Солонгосын иргэний нийгмийн байгууллагуудын оруулсан хувь нэмэр, бодлого, хууль тогтоомжийн нөлөөлөлд эрдэмтэн судлаач, мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах, хэрхэн олон нийтийн өргөн дэмжлэгийг авч байгууллагын үйл ажиллагааны үр нөлөө, санхүүгийн тогтвортой байдлыг хангаж буй зэрэг туршлага нь Монголын иргэний нийгмийн байгууллагуудад цаашдын стратеги,

бизнес төлөвлөгөөгөө боловсруулахад нь үнэтэй хувь нэмэр оруулна гэдэгт найдаж байна. Түүнчлэн олон нийтийн өргөн дэмжлэгийг авах, нийгмийн сайн сайхны төлөөх үйл ажиллагаанд зориулан хөрөнгө босгох асуудлаар мэргэшсэн байгууллагатай уулзалт хийж, монголын иргэний нийгмийн байгууллагуудын хөрөнгө босгох чадавхыг нэмэгдүүлэх талаар цаашид хамтран ажиллахаар болсон нь манай төрийн бус байгууллагуудад тулгарч буй хамгийн том бэрхшээлийн нэг болох санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулах юм.

Туршлага судлах аялалд оролцсон төрийн бус байгууллагууд аяллын хугацаанд олж мэдсэн байгууллагын тогтвортой хөгжлийг хадгалах шинэлэг арга туршлага дээрээ суурилан цаашид өөрийн байгууллагынхаа хөгжлийн стратегийг боловсруулан ажиллахад нь ННФ дэмжлэг үзүүлж байгаа болно.

Доорх зурагт туршлага судлах аялалд оролцсон төрийн бус байгууллагуудын төлөөлөл
2015 оны 1 дүгээр сард.



ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ЦУВРАЛ ВИДЕО НИЙТЛЭЛ: Иргэний нийгмийн байгууллагуудын ардчилал, шударга ёс, хүний эрх, хүрээлэн буй орчныг хамгаалахад оруулж буй хувь нэмэр төдийлөн сайн танигдаагүйгээс төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаанд хандах нийгмийн үнэлэмж, дэмжлэг сул байна. Иймд ННФ сайн засаглалыг бэхжүүлэх, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, хүний эрх, байгаль орчныг хамгаалахад бодитой хувь нэмэр оруулан амжилттай ажиллаж байгаа төрийн бус байгууллагуудыг үйл ажиллагаагаар нь дамжуулан олон нийтэд таниулах зорилгоор тэдний үйл ажиллагааны тухай богино хэмжээний баримтат кино буюу видео нийтлэл бэлтгэлээ.

Энэ хүрээнд мэдээллийн ил тод байдал, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, гэр бүлийн хүчирхийллээс сэргийлэх, нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжтэй байдал, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах, нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах, эрдэс баялгийн салбарын болон төсвийн ил тод байдлыг хангах чиглэлээр төрийн бус байгууллагуудын чухалчлан ажилладаг сэдвээр 8 нэвтрүүлэг бэлтгэн, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр орон даяар дамжууллаа.

ННФ-ын бэлтгэсэн дээрх нэвтрүүлгүүдийг бүрэн эхээр нь үзэхийг хүсвэл манай www.forum.mn цахим хуудсанд зочилно уу.

Манай бэлтгэсэн нэвтрүүлгүүдийг олон нийтийн хүртээл болгоход туслалцаа үзүүлж хамтран ажилласан МҮОНРТВ, UBS ТВ, LikeHD ТВ, NTV, Хөвсгөл, Дорнод, Өмнөговь, Төв аймгийн телевизүүд болон бусад байгууллага, хүмүүст талархал илэрхийлье.

**ИНБ-УУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ
ВИДЕО НИЙТЛЭЛИЙН ЖАГСААЛТ,
НЭВТРҮҮЛСЭН ТЕЛЕВИЗҮҮД**

1. “Хайр хүчирхийлэл дор цэцэглэхгүй”
2. “Нийтийн эрх ашгийг нэхэмжлэхүй”
3. “Тэгш боломж, Хүртээмжтэй үйлчилгээ”
4. “Төсвийн хяналт ил тод байдлаас ...”
5. “Бид мэдэх эрхтэй”
6. “Ил тод байдал, хариуцлага”
7. “Эрх тэгш боловсрол”
8. “Далай юу, фосфорит уу?”



ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ХӨТӨЛБӨР

- ОУИТБС-ын эрх зүйн орчныг сайжруулахад иргэний нийгмийн санал, зөвлөмжийг тусгууллаа.
- Нөлөөллийн ажлын үр дүнд Засгийн газрын 104-р тогтоолоор Бүтээгдэхүүн хуваах гэрээ олон нийтэд ил болох шийдвэр гарав.

Төрийн өмчит компаниудын
Засаглалын үнэлгээнд

- 9 уул уурхайн компани
- 13 эрчим хүчний компани хамрагдав.

- Улсыг болон орон нутгийн төсвийн ил тод байдлыг үнэлэв.
- Сум хөгжүүлэх болон Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийн зарцуулалт, ил тод байдалд иргэний нийгмийн 12 байгууллага мониторинг хийж байна.

ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЗАСАГЛАЛ, ТОД БАЙДАЛ



Ухаа худаг, 2014 оны 11 сар
Гэрэл зургийг Б.Мөнхгэрэл

Монгол Улс 2014 онд Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын 8 дахь тайлангаа гаргалаа. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОҮИТБС)-ын онцлог давуу тал болох төр, иргэний нийгэм, бизнесийн эрх тэгш хамтын ажиллагаа улам баталгаажиж, үр нөлөө нь дээшилсний үр дүнд манай улс тайландаа анх удаа энэ салбарт хийгдсэн гэрээний болон олгосон тусгай зөвшөөрлийн мэдээлэл, олборлох үйл ажиллагаанаас ашиг хүртэгч жинхэнэ эздийн ил тод байдал зэргийг шинээр оруулснаас гадна газрын тос, байгалийн хий, цацраг идэвхт ашигт малтмалын үйл ажиллагаа эрхлэгч компаниуд тайланд хамрагддаг боллоо. Түүнчлэн уул уурхай, эрдэс баялгийн салбарын засаглалын асуудлаар дагнан ажилладаг “Төлсөн авснаа нийтэл эвсэл” (ТАН эвсэл) төрийн бус байгууллагуудын сүлжээ улам бэхжиж, хяналт мониторинг хийх, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоход нөлөөлөх, орон нутгийн иргэдэд мэдээлэл хүргэх, тэднийг чадавхжуулах, гэрээний ил тод байдлыг шаардах зэргээр эрдэс баялгийн салбарын хөгжилд бодитой хувь нэмэр оруулж байна.

ОҮИТБС-д манай улс нэгдэн орох, түүнийг үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд эхнээс нь тууштай дэмжиж ирсэн ННФ 2014 онд (i) олборлох үйлдвэрлэлийн салбарын ил тод байдлыг хангах эрх зүйн орчныг сайжруулах, (ii) эрдэс баялгийн салбар дахь гэрээний ил тод байдлыг хангах, (iii) ОҮИТБС, түүний шинэ стандартыг хэрэгжүүлэхэд хяналт тавих иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж, чадавхыг бэхжүүлэхэд гол анхаарлаа хандуулж ажиллалаа.

ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ ХҮРЭЭНД: ОУИТБС-ыг хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалт бий болгох, санаачилгын үр дүнг дээшлүүлэхэд төр, иргэний нийгэм, хувийн хэвшил хамтран ажиллаж ирсэн сайн туршлагыг хуульчлах чиглэлээр иргэний нийгмийн байгууллагуудын санаачилга, үйл ажиллагааг дэмжиж ажиллав. Энэ салбар дахь иргэний нийгмийн гол төлөөлөл болсон ТАН эвсэл нь ННФ-ын санхүүгийн дэмжлэгтэйгээр “Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай” хуулийн төсөл боловсруулахад оролцож, иргэний нийгмийн санал, зөвлөмжийг тусгууллаа. Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын хамрах хүрээ, зарчим, түүнийг хэрэгжүүлэгч байгууллагын бүтэц, эрх үүрэг, санхүүжилт, ОУИТБС-ын тайлантай холбоотой талуудын эрх үүрэг, хариуцлага, хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага зэрэг харилцааг зохицуулсан 4 бүлэг 17 зүйлтэй хуулийн төсөл боловсруулахад оролцож, УИХ-д өргөн бариад байна.

ННФ бодлого боловсруулагчдад эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хуульчилж буй олон улсын чиг хандлагын талаар ойлголт, мэдээлэл өгөх зорилгоор “Гадаад орнуудын ОУИТБС-ын тухай хууль тогтоомжийн харьцуулсан судалгаа”-г хийж, холбогдох талуудад хүргүүлжээ. Өнөөдөр дэлхийн 48 улс ОУИТБС-д нэгдэн, хэрэгжүүлж байгаагаас 31 нь уг Санаачилгыг “хэрэгжүүлэгч улс” статусыг аваад байна. Эдгээрээс Либери, Нигери, Норвеги, Европын холбоо, Англи, АНУ, Канад зэрэг улс ОУИТБС-ыг хэрэгжүүлэхтэй холбоотой бие даасан хууль батлан гаргажээ. Эдгээр улсын хуулиуд дахь ОУИТБС-ыг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааны нарийн зохицуулалтууд нь эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангах эрх зүйн орчныг бүрдүүлэхийг зорьж буй манай орны хувьд судалгааны ач холбогдолтой юм. Ялангуяа дэлхийн өндөр хөгжилтэй улс орнууд болох Европын холбоо, Англи, АНУ, Канад зэрэг улс нь олборлогч компаниудад үйл ажиллагаагаа төсөл тус бүрээр тайлагнах, түүний дотор улсын дотоодод төлсөн төлбөр, орлогоос гадна гадаад улсын засгийн газарт төлсөн төлбөрөө ч тайлагнах үүргийг хүлээлгэсэнээрээ онцлогтой байна.

ГАДААД ОРНУУДЫН ОУИТБС-ЫН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА



Дэлхийн өндөр хөгжилтэй зарим улс орон дотооддоо төдийгүй гадаад улсын засгийн газарт төлсөн төлбөрөө ч тайлагнах үүргийг олборлогч компаниудад хүлээлгэдэг байна.

Зарим орон тухайлбал, Либер Улс Санаачилгад ашигт малтмал, газрын тос, байгалийн хийн олборлолтоос гадна хөдөө аж ахуй, ой мод ашиглах чиглэлийн үйл ажиллагааг хамруулдаг. Тэрчлэн олборлогч компаниудын төлсөн төлбөр, орлогоос гадна олборлох салбарт хийсэн гэрээ, концесс, тусгай зөвшөөрлийг олон нийтэд нээлттэй байхаар хуульчилжээ.


Судалгааны тайланг бүрэн эхээр нь www.forum.mn цахим хуудаснаас үзнэ үү.

2013 онд ОУИТБС-ын стандарт шинэчлэн батлагдсанаар газрын тос, байгалийн хий, цацраг идэвхт ашигт малтмалын үйл ажиллагаа эрхлэгч компаниуд тайлан гаргах үүрэгтэй болсон юм. Түүнчлэн шинэ стандартаар гэрээний болон тусгай зөвшөөрлийн мэдээлэл, олборлох үйл ажиллагаанаас ашиг хүртэгч жинхэнэ эздийн ил тод байдал зэрэг мэдээллийг тайланд нэмж тусгадаг боллоо. Манай улс ОУИТБС-д нэгдэн орсноос хойш нийт 8 тайлан гаргаж байгаа ба үүнээс сүүлийнх нь буюу 2013 оны Үндэсний нэгтгэл тайланг анх удаа дээрх шинэ стандартын дагуу гаргаад байна. Жилээс жилд тайлан гаргаж буй аж ахуйн нэгжийн тоо 2012 он хүртэл нэмэгдэж байв. Харин энэ өсөлт 2013 онд 330 орчим аж ахуйн нэгжээр буурчээ. Анх 2006 онд 64 аж ахуйн нэгж төв, орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөр, хураамж, болон бусад орлогын мэдээллээр тайлан гаргаж байсан бол 2013 онд 1198 болов.

Ийнхүү ОУИТБС-ын тайлан гаргаж буй аж ахуйн нэгжийн тоо жил ирэх бүр нэмэгдэн, улам өргөн

хүрээний нарийн мэдээлэл тайлагнах шинэ стандарт хэрэгжиж эхэлж байгаа боловч зарим тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, төрийн захиргааны байгууллага тайлан гаргах ажилд хойрго хандах, ирүүлсэн тайлангийн мэдээ, тоо баримт зөрөх тохиолдол байнга гардаг. Тухайлбал, 2013 оны Нэгтгэл тайлангаар 36 840 000 төгрөгийн зөрүү илэрчээ. Эдгээр зөрүүтэй байдлыг нэгдсэн тайлан гаргах үед эргэж тодруулахад идэвхгүй хандах, тайлангаар илэрсэн зөрүүний шалтгааныг тогтоож, хариуцлага тооцох ажил хийгдэхгүй байх зэрэг дутагдал засагдахгүй давтагдсан хэвээр байна. Иймд ОУИТБС-ыг хэрэгжүүлэх үйл явцыг хуульчлан баталгаажуулах, оролцогч талуудын эрх үүрэг, хариуцлагыг тодорхой болгон уялдаа холбоог сайжруулах шаардлага зүй ёсоор урган гарч байгаа юм. Ялангуяа Санаачилгын хэрэгжилтэд үнэтэй хувь нэмэр оруулсаар ирсэн иргэний нийгмийн тэгш оролцоог баталгаажуулах, үйл ажиллагааг дэмжих, чадавхыг бэхжүүлэх нь хойшлуулшгүй зорилт болж байна.

2006-2013 ОНД ОУИТБС-ЫН ТАЙЛАН ГАРГАСАН КОМПАНИУДЫН ТОО



Нэгтгэл тайлангуудаар компанийн өгсөн, Засгийн газрын авсан татварын мэдээлэл хоорондоо тохирохгүй байх явдал давтагдсаар байна. Энэ нь талууд зөрүүг тайлбарлах нэмэлт мэдээлэл гаргаж, тодруулга хийхдээ хойрго ханддагтай холбоотой.

ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАР ДАХЬ ГЭРЭЭНИЙ ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР:

Төр, олборлох үйлдвэрлэл эрхлэгчид болон иргэний нийгмийнхний ойлголт, байр суурийг нэгтгэх, хамтын ажиллагааны эхлэлийг тавихыг зорьж “Эрдэс баялгийн салбар дахь гэрээний ил тод байдал” олон талт хэлэлцүүлгийг УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо, Уул уурхайн яам, ОУИТБС-ын Ажлын алба, ТАН эвсэл, Уул уурхайн үндэсний ассоциаци зэрэг талуудтай хамтран зохион байгууллаа.

Хэлэлцүүлэгт эрдэс баялгийн салбарт үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, олборлох үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжүүд, олон улсын байгууллага, орон нутгийн төлөөлөл зэрэг 100 гаруй хүн оролцож, эрдэс баялгийн салбар дахь гэрээний

ил тод байдалтай холбоотой өнөөгийн хууль тогтоомж, гэрээг ил тод болгоход тулгарч буй асуудал, тэдгээрийг шийдвэрлэх арга замыг хэлэлцлээ. Талууд гэрээний ил тод байдлыг хангах талаар хамтран ажиллахаар санал нэгдэж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон нь хэлэлцүүлгийн гол үр дүн байлаа.

Уг хэлэлцүүлгээс гэрээний ил тод байдлыг хангах Зөвлөмж гаргасан нь үр дүнд хүрч тодорхой ажлууд хийгдэж эхлээд байна. Тухайлбал, Сангийн яам, Газрын тосны газар, олборлох үйлдвэрлэл эрхлэгчид, иргэний нийгмийн төлөөллийг оролцуулан Гэрээний ил тод байдлыг хангах асуудлаар ажиллах Ажлын хэсэг Уул уурхайн яаманд байгуулагдан ажиллаж байна. Ажлын хэсэг нь хэлэлцүүлгийн Зөвлөмжид заасны дагуу

**ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРТ ГЭРЭЭНИЙ ИЛ ТОД БАЙДЛЫГ
ХАНГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗӨВЛӨМЖ**

- Эрдэс баялгийн салбарт гэрээ байгуулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтийг хянах, үнэлэх зэрэг бүх шатанд ил тод байдлыг бүрэн хангахын тулд холбогдох мэдээллийг нээлттэй болгох, гэрээний төслийг олон нийтээр хэлэлцүүлэх, гэрээ байгуулах хэлэлцээрт иргэний нийгмийн оролцоог хангах, батлагдсан гэрээг олон нийтэд ил тод болгоход чиглэсэн эрх зүйн цогц орчныг бий болгох. Ингэхдээ Засгийн газраас хөрөнгө оруулагчтай хийж буй гэрээнүүдийн хэрэгжилтэд төр, иргэний нийгэм хамтран хяналт тавих эрх зүйн орчныг бүрдүүлэх;
- Газрын тосны газар нь бүтээгдэхүүн хуваах гэрээний ил тод байдлыг эрх зүйн хувьд баталгаажуулах үүднээс бүтээгдэхүүн хуваах гэрээний загвараас нууцлалын заалтыг хасах асуудлыг авч үзэх;
- Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийг ил тод, нээлттэй болгох талаар гэрээний талууд санаачилга гарган хамтран ажиллах;
- Засгийн газар, түүний холбогдох байгууллагаас ашигт малтмал, газрын тосны салбарт хөрөнгө оруулагч, тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй байгуулсан Тогтвортой байдлын гэрээ, Хөрөнгө оруулалтын гэрээ, Бүтээгдэхүүн хуваах гэрээ болон Геологийн ажлын гэрээ, Ашиглалтын өмнөх гэрээг төрийн холбогдох байгууллагын цахим хуудаст байршуулах замаар бүхэлд нь олон нийтэд ил тод болгох;
- Эрдэс баялгийн салбарын гэрээний ил тод байдал, мэдээллийн хүртээмж, зохион байгуулалтыг хангах үүднээс ОУИТБС-ын Ажлын алба гэх мэт эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хариуцан ажилладаг байгууллагын дэргэд гэрээний мэдээллийн нэгдсэн сан үүсгэж, энэ салбарт байгуулагдсан бүх гэрээг системтэйгээр байршуулах;
- Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн дагуу нутгийн захиргааны болон өөрөө удирдах ёсны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулдаг гэрээг орон нутгийн захиргааны байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах.

Гэрээний нэгдсэн сан байгуулж, одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа гэрээнүүдийг ил тод болгох, гэрээний ил тод байдлыг хангах эрх зүйн орчны судалгаа хийхээр ажиллаж байна.

Түүнчлэн Газрын тосны газраас Бүтээгдэхүүн хуваах гэрээний загварыг 2015 онд шинэчлэн боловсруулж, хэлэлцүүлгийн мөрөөр гэрээний загвараас нууцлалын заалтыг хассан нь хэлэлцүүлгийн гол үр дүн байлаа. Засгийн газрын 2015 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 104 дүгээр тогтоолоор батлагдсан шинэчилсэн загварын дагуу ирээдүйд байгуулагдах Бүтээгдэхүүн хуваах гэрээ олон нийтэд ил тод байх боломж бүрдлээ.

ОУИТБС-ЫН ШИНЭ СТАНДАРТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ, ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ХҮРЭЭНД: 30 гаруй төрийн бус байгууллагыг эгнээндээ нэгтгэсэн “ТАН эвсэл”-ийн үйл ажиллагаанд

дэмжлэг үзүүлж ажиллалаа. Уул уурхайн салбарын ил тод, хариуцлагатай байдлын асуудлаар тогтвортой ажилладаг иргэний нийгмийн байгууллагууд бий болж, үйл ажиллагаа нь төлөвшин ОУИТБС-ын хэрэгжилтэд амжилттай оролцож байгаа боловч цаашдаа судалгаа, дүн шинжилгээ хийх, гэрээний үр ашиг, хэрэгжилтийг хянах, төрийн бодлого шийдвэрт үр нөлөөтэй оролцоход ТББ-уудын чадавх хангалттай сайн биш байна. Иймээс ННФ ТАН эвсэлийн үйл ажиллагаагаар дамжуулан олборлох салбарын асуудлаар тууштай ажилладаг иргэний нийгмийн байгууллагуудыг дэмжих, чадавхжуулахад байнга анхаарч тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлэн, хамтран ажиллаж ирлээ. ТАН эвсэлээс 2014 онд ННФ-ын санхүүгийн дэмжлэгтэйгээр уул уурхайн үйл ажиллагааны нөлөөлөлд өртөж буй орон нутгийн иргэдийг мэдээллээр хангах, шийдвэр гаргах үйл явцад оролцох, хяналт тавих чадавхыг бэхжүүлэх зорилгоор дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:



Дээрх зурагт зүүн гар талаас: “Эрдэс баялгийн салбар дахь гэрээний ил тод байдал” олон талт хэлэлцүүлэгт оролцогчид, Эрдэнэс Оюу толгой ХХК-ийн Гүйцэтгэх захирал Да.Ганболд хэлэлцүүлгийн үеэр санал зөвлөмж хэлж байгаа нь 2014 оны 12 сарын 18-ны өдөр.

- Дундговь, Дархан-Уул, Баянхонгор аймаг, Улаанбаатар хотын ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН мэдээллийн хуудсыг бэлтгэн орон нутгийн иргэдэд түгээв.
- ОУИТБС, түүний шинэ стандартыг орон нутагт хэрэгжүүлэх чиглэлээр сургагч багш нарыг бэлтгэн 12 аймгийн 17 суманд сургалт, хэлэлцүүлэг зохион байгууллаа.
- ОУИТБС-ыг орон нутагт хэрэгжүүлэх дэд зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулсан Засгийн газрын 222-р тогтоолын хэрэгжилтэд мониторинг хийж, дүнг холбогдох талуудад танилцуулав.
- ТАН эвслийн гишүүн Хил хязгааргүй алхам ТББ нь Орон нутагт ОУИТБС-ын Олон талт хэлэлцүүлэг зохион байгуулах тухай гарын авлагыг боловсруулсан нь хэвлэгдэх шатандаа явж байна.
- ОУИТБС-ын хэрэгжилтийг сайжруулах нэг алхам бол Нэгтгэл тайланд тусгагдсан зөвлөмжийн хэрэгжилтийг хангах явдал юм. Учир нь жил бүрийн нэгтгэл тайлангаар ОУИТБС-ын тайлангийн чанар, үр нөлөөг сайжруулахтай холбоотой олон тооны зөвлөмж гардаг боловч тэдгээрийг хэрэгжүүлэх дорвитой ажил хийгдэхгүй үлддэг байна. Иймээс ТАН эвсэлийн гишүүн Хүний эрх хөгжил төв, Зориг сан зэрэг байгууллага ОУИТБС-ын 2006-2011 оны Үндэсний нэгтгэл тайлангуудаар гаргасан зөвлөмжийн хэрэгжилтэд мониторинг хийлээ. Мониторингийн дүнгээс харахад ОУИТБС-ын 2006-2011 оны 6 удаагийн тайлангаар нийт 129 зөвлөмж гаргаснаас 89 нь давхардсан буюу давтагдаж гарсан зөвлөмж байжээ. Түүний дотор 28 зөвлөмж 2-5 удаа давтагдаж гарчээ. Нийт зөвлөмжийн хэрэгжилтийг авч үзэхэд зөвхөн 8 зөвлөмж буюу ердөө 20 хувь нь бүрэн хэрэгжсэн гэж дүгнэсэн нь зөвлөмжийн хэрэгжилт маш сул байгааг харууллаа. Үндэсний нэгтгэл тайланг бэлтгэх, хэлэлцүүлэх, батлахтай холбоотой дүрэм журамд тайланд тусгагдсан зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, үүнтэй холбоотой талуудын эрх үүргийг тодорхой тусгаагүй байгаа нь зөвлөмжийн хэрэгжилт сул байх гол шалтгаан болжээ. Мониторингийн мөрөөр ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн үйл ажиллагааны журамд дээрх зөвлөмжийн хэрэгжилтийг хангахтай холбоотой өөрчлөлт оруулахаар ажиллаж байна.
- Түүнчлэн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын ОУИТБС-ын тайланд хамрагдсан байдал, ОУИТБС-ын 2010-2013 оны Үндэсний тайлангаас орон нутгийн хандив тусламжийн дүн шинжилгээ, Авлигатай тэмцэх газар дахь хөрөнгө орлогын мэдүүлгээс орон нутгийн албан тушаалтнуудын хөрөнгө орлогын түүвэр судалгаа хийлээ.

ТӨСВИЙН ИЛ ТОД БАЙДАЛ БА ИРГЭДИЙН ОРОЛЦОО

Монгол Улсад төсвийн ил тод байдал, хариуцлагыг сайжруулахад 2014 он эргэлтийн жил боллоо. Шилэн дансны тухай хууль батлагдан гарч, төсвийн байгууллагуудын дансны гүйлгээ нийтэд ил тод болох эрх зүйн орчин бүрдлээ. Ийнхүү төсөв, түүний зарцуулалтын ил тод байдал хуулиар баталгаажсан нь төсвийн ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулах чиглэлээр сүүлийн 10 гаруй жил бусад иргэний нийгмийн байгууллага, судлаачидтай хамтран судалгаа шинжилгээ, үнэлгээ мониторинг, нөлөөллийн үйл ажиллагаа явуулж ирсэн ННФ-ын хувьд

цаашид ажиллах ихээхэн урам зориг, эрч хүч нэмлээ.

Бид өнгөрсөн онд үйл ажиллагааны стратегийнхаа дагуу (i) төсвийн ил тод байдалд ажиглалт мониторинг хийх, (ii) төв засгийн газрын төсвийн нээлттэй байдлыг олон улсын түвшинд тодорхойлох, (iii) орон нутгийн төсвийн ил тод байдлын түвшинг тодорхойлох, (iv) төсвийн чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагуудын чадавхыг нэмэгдүүлэхэд гол үйл ажиллагаагаа чиглүүллээ.

Төсвийн мэдээллийн ил тод байдлын мониторинг

Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай болон Төсвийн тухай хуулийн ил тод, нээлттэй байдлыг хангахтай холбоотой заалтууд, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн зарим заалтын хэрэгжилтэд мониторинг хийх иргэний нийгмийн 12 байгууллагад тэтгэлэг олгов. Тэтгэлгийн хүрээнд Сум хөгжүүлэх сан (СХС) болон Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан (ХЭДС)-гийн хөрөнгийн зарцуулалтын мэдээллийн ил тод байдал, иргэдийн оролцоонд мониторинг хийж байна.

Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-

ын хэрэгжилтэд 8 байгууллага хяналт тавьж, Сангийн төсвийг хууль, журмын дагуу зарцуулж байгаа эсэх, мэдээллийн ил тод, хүртээмжтэй, нээлттэй байдалд үнэлгээ хийж, олон нийтийн оролцооны түвшинг тодорхойлон санал зөвлөмж гаргах, нөлөөллийн үйл ажиллагаа явуулахаар ажиллаж байна. Үүнд, “Хөвсгөлийн хөгжил, дэвшилд”, “Итгэлийн бяцхан элч сан”, “Төр-Иргэн Түншлэл”, “Онол-Арга” ТББ-ууд, “Нийгмийн дэвшил, эмэгтэйчүүдийн холбоо”-ны Дархан-Уул дахь салбар, Өвөрхангай болон Дорнод аймаг дахь “Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан”-гийн салбар зөвлөлүүд болон Улс төрийн боловсролын академийн Дорнод

аймаг дахь салбар байгууллага нийтдээ 9 аймгийн 44 суманд тус тусдаа мониторинг хийж байна. Төслийн үр дүнд СХС-гийн журмын хэрэгжилтийн өнөөгийн байдал тодорхой болж, мэдээллийн ил тод, хүртээмжтэй, нээлттэй байдал сайжрах, сангийн талаарх иргэдийн мэдлэг нэмэгдэх ач холбогдолтой юм.

Засгийн газрын 2011 оны 375 дугаар тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл, санхүүгийн дэмжлэг олгох журам”-ын хэрэгжилтэд ННФ-ын дэмжлэгтэйгээр 5 аймаг, 6 сум, Улаанбаатар хотын 6 дүүрэгт мониторинг хийж байна. Тухайлбал, Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн хөдөлгөөний Өмнөговь аймаг дахь салбар, Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чөлөөт үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо, “Ховд Бат-Итгэл”, “Захиргааны Шинэ Санаачилга” ТББ-ууд ХЭДС-гийн бүрдүүлэлт, зарцуулалт, тайлагналт, энэ үйл явц дахь иргэдийн хяналт, оролцооны байдлыг ажиглан нөлөөллийн ажил явуулж байна. Эдгээр мониторингийн дүнг 2015 онд нийтэд танилцуулна.

Шилэн дансны хуулиар төрийн төсөв, санхүүгийн мэдээлэл ил тод болж байгаа энэ үед хөгжлийн албан ёсны зээл, тусламжийн мэдээлэл олдоц муутай байгааг “Хүнс эвсэл” иргэний нийгмийн сүлжээний мониторинг харууллаа. Хандивлагч, тэдний түнш төрийн яамдын вэб хуудсыг шүүж үзэхэд зээл, тусламжаар хэрэгжүүлэх үйл ажиллагааны төсөв хөрөнгө, гүйцэтгэлтэй холбоотой мэдээлэл огт байхгүй, байгаа нь хэт ерөнхий, эсвэл англи хэл дээрх мэдээ байжээ. Харин албан захидлаар хандаж мэдээлэл хүсэхэд ихэнх байгууллага хариу өгч, зарим нь тусгайлан мэдээ боловсруулж өгсөн нь сайшаалтай. “Зээл, тусламжийн ажиглагч” нэртэй энэ төсөл нь цаашид хөгжлийн албан ёсны зээл, тусламжийн мэдээллийг авч ашиглахад хялбар, хүртээмжтэй болгох асуудлаар олон талт хэлэлцүүлэг, бусад

нөлөөллийн ажил явуулах юм. Мөн гадаадын зээл, тусламжийн үйл ажиллагаанд мониторинг хийх хэрэгцээ шаардлагыг тодорхойлохоос гадна арга зүйн сургалт семинар, мэдээллийн ажил төлөвлөөд байна. ННФ уг төслийн үйл ажиллагааг дэмжин, тэтгэлэг өгч ажиллаж байгаа болно.

“Шилэн дансны тухай” хууль 2015 оны 1 дүгээр сарын 1-ээс хэрэгжиж эхэлсэн бөгөөд хуулиар төсвийн бүх байгууллага, төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой үйлдвэрийн газрууд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт, орлого, зарлагын гүйлгээ тус бүрээ ил тод мэдээлэх шаардлагатай болсон. Хууль зөрчсөн тохиолдолд иргэд, хуулийн этгээдээс төрийн аудитын байгууллагад өргөдөл, гомдол гарган шийдвэрлүүлэх эрхтэй болж, хууль зөрчсөн албан тушаалтан хариуцлага хүлээх болов. Энэ нь хуулийн хэрэгжилтийг хангасан нөхцөлд төсвийн хариуцлага дээшлэх нэн ач холбогдолтой шийдвэр билээ.

ШИЛЭН ДАНСНЫ ХУУЛЬ

“Шилэн дансны тухай” хууль 2014 оны 7 дугаар сард, “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай” журам 12 дугаар сард тус тус батлагдсан. Хуулиар төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газар төсвийн 28 төрлийн мэдээллийг мэдээллийн самбар болон цахим хуудсаараа нийтэд мэдээлэх үүрэгтэй юм. Журамд зааснаар мэдээллийг 19 төрлийн маягтаар PDF, Excel, XML форматаар нийтэлнэ.

“Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтийг хангахад иргэний нийгмийн зүгээс хийх хяналт, оролцоо чухал юм. ННФ-ын зүгээс хуулийн хэрэгжилтийг Монгол Улсын 21 аймаг, нийслэл, дүүргүүдэд хэрхэн хангаж байгаад мониторинг хийхээр төлөвлөж бэлтгэл ажилдаа

ороод байна. Хуулийн хэрэгжилтийг ажиглан мониторинг хийх байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх зорилгоор тайлант оны 12 дугаар сард орон нутгийн 30 гаруй иргэний нийгмийн байгууллагаас сонгогдсон төлөөлөгчдөд арга зүйн сургалт хийлээ.

Төв засгийн газрын төсвийн ил тод байдлын судалгаа

Бид Монгол Улсын төв засгийн газрын төсвийн ил тод байдлыг үнэлэн судалж, дүнг олон нийтэд мэдээлэх, дүнд тулгуурлан ил тод байдлыг сайжруулах нөлөөллийн үйл ажиллагааг 2006 оноос эхлэн явуулж байна. Уг шинжилгээг дэлхийн улс орнуудын төв засгийн газрын төсвийн ил тод байдлын “Нээлттэй төсвийн судалгаа”-г зохион байгуулдаг АНУ-д төвтэй Олон улсын төсвийн түншлэл байгууллага (www.internationalbudget.org)-ын аргачлалын дагуу хийдэг. “Нээлттэй төсвийн судалгаа”-гаар 100 гаруй орны төв засгийн газрыг төсвийн найман гол баримт бичгийг олон нийтэд хэрхэн ил тайлагнасан, мөн эдгээр баримт бичигт орсон мэдээллийн иж бүрэн, шуурхай, ашиглаж болохуйц байдалд үнэлгээ өгдөг. Уг судалгаанд Олон улсын валютын сан, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага, Олон

улсын аудитын дээд байгууллага зэрэг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагуудын боловсруулсан, шалгуур үзүүлэлтээр төсвийн ил тод байдлыг үнэлж, нэгдсэн индекс гаргадаг.

НЭЭЛТТЭЙ ТӨСВИЙН СУДАЛГААНД ХАМРУУЛДАГ ГОЛ БАРИМТ БИЧГҮҮД

- Төсвийн урьдчилсан мэдэгдэл
- Гүйцэтгэх засаглалын төсвийн санал
- Батлагдсан төсөв
- Иргэдэд зориулсан төсөв
- Жилийн явцын тайлангууд
- Хагас жилийн тойм
- Жилийн эцсийн тайлан
- Аудитын тайлан



Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд мониторинг хийх аргагүйн сургалтад оролцогчид Нээлттэй Нийгэм Форум, 2014 оны 12 дугаар сар.

Манай улс энэхүү судалгаанд тав дахь удаагаа оролцож байна. 2006-2012 онд хийгдсэн судалгаагаар Монгол Улсын төсвийн ил тод байдал хангалтгүй байгаа нь харагдсан. Нийт авбал зохих 100 онооноос 2006 онд 18, 2008 онд 36, 2010 онд 60 харин 2012 онд 51 оноо

авчээ. 2014 онд хийгдсэн судалгааны урьдчилсан дүнгээс харахад Монгол Улсад төсвийн ил тод байдал хангалтгүй хэвээр байна. “Нээлттэй төсвийн судалгаа”-ны эцсийн дүнг судалгааг хийсэн түнш байгууллагууд 2015 онд дэлхий даяар нэгэн зэрэг танилцуулах юм.

Орон нутгийн төсвийн ил тод байдлын түвшинг тодорхойлох судалгаа

Төсвийн төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд орон нутгийн төсвийн эрх мэдэл нэлээд нэмэгдсэн билээ. Ийм нөхцөлд орон нутгийн төсвийн ил тод, нээлттэй байдлыг хангах нь чухал юм. ННФ-аас орон нутаг дахь төсвийн ил тод байдлын түвшинг тодорхойлох анхны судалгааг 2011 онд хийж гүйцэтгэсэн бөгөөд хоёрдахь судалгааг 2013-2014 онд хийлээ. Судалгааны хүрээнд 21 аймаг, нийслэл хотод 2013 оны төсвийн үйл явц болон тухайн жилийн туршид гарсан баримт бичгүүд тухайлбал, 2012

оны төсвийн гүйцэтгэл, 2013 оны төсвийн зарцуулалтын үйл явц, 2014 оны төсвийн төсөл, түүнийг хэлэлцэх үйл явц, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө зэргийн ил тод байдлыг үнэлэв.

Судалгаагаар орон нутагт төсвийн ил тод байдал хангалтгүй байгаа нь харагдлаа. Аймаг, нийслэлийн дундаж оноо 36 буюу нийт авбал зохих 100 онооны дөнгөж гуравны нэгд хүрч байна. 2011 оны судалгаагаар энэ үзүүлэлт 35

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН СУДАЛГАА



ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ИЛ ТОД БАЙДАЛ - 2013



График 4. Аймаг, нийслэл хотод төсвийн ил тод байдлын түвшинг тодорхойлох судалгаа

ННФ-аас эрхлэн 21 аймаг, нийслэл хотод төсвийн үйл явцтай холбогдох баримт бичгүүдийг ил тод болгосон байдалд судалгаа хийж, дүнг олон нийтэд танилцуулав. “Орон нутгийн төсвийн ил тод байдал-2013” тайланг бүрэн эхээр нь www.forum.mn вэб сайтаас үзнэ үү.

байсан юм. Энэ нь төсвийн ил тод байдлыг хангах талаар гарсан хууль тогтоомжийн хэрэгжилт орон нутгийн захиргааны байгууллагуудын анхаарлын төвд ороогүй байгааг харуулж байна. Энэхүү судалгааны дүн нь төсвийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, иргэдийн оролцоог сайжруулах талаар олон

нийт, бодлого боловсруулагчид, орон нутгийн удирдлагуудын дунд хэлэлцүүлэг өрнүүлэхэд хувь нэмэр оруулахын зэрэгцээ орон нутгийн төсөв болон түүний ил тод байдлын эрхзүйн шаардлагуудын талаар иргэний нийгмийн байгууллагын ажилтнуудын мэдлэг дээшлэх ач холбогдолтой юм.

“Иргэд төсвөө хянана” сүлжээний үйл ажиллагаа

ННФ-аас “Иргэд төсвөө хянана” иргэний нийгмийн сүлжээний үйл ажиллагааг дэмжиж ажилладаг. Тус сүлжээний энэ онд хийсэн гол ажлуудаас дурдвал, төсвийн мэдээллийн www.tusuv.mn цахим хуудсыг үргэлжлүүлэн ажиллуулж, сүлжээний гишүүн байгууллагуудын ажиглалт, мониторингийн явцад олж авсан төсвийн холбогдолтой мэдээллийг байршуулж олон нийтэд тогтмол хүргэж ирлээ.

Мөн “Иргэд төсвөө хянана” сүлжээ 2015 оны орон нутгийн төсвийн төслийг боловсруулах, Иргэдийн төлөөлөгчдийн хурал (ИТХ)-д өргөн барих, ИТХ-ын хуралдаанаар хэлэлцэж

батлах үйл явц болон батлагдсан төсвийн ил тод, нээлттэй байдалд мониторинг хийв. Мониторингод Улаанбаатар хот, түүний дөрвөн дүүрэг, 10 аймгийг хамруулан ажиглалт хийж буй байгууллагуудаас ирүүлсэн баримт материал, нотолгоог цахим сайтад байршуулан иргэд, олон нийт, татвар төлөгчдөд хүргэх, судлаач шинжээчдээр үнэлэлт дүгнэлт хийлгэх замаар орон нутгийн төсвийн үйл явц, хэрэгжилтэд хяналт тавих, оролцох үйл ажиллагааг явуулж байна. Энэ ажил 2015 онд үргэлжилж байгаа болно.

ТӨСВИЙН МЭДЭЭЛЛИЙН WWW.TUSUV.MN ВЭБ САЙТ



www.tusuv.mn цахим хуудас нь төрийн байгууллагууд татвар төлөгчдийн мөнгийг хэрхэн зарцуулж байгаа талаар мэдээлэл цуглуулж, нийтэд мэдээлэх зорилготой. Энэ цахим хуудсыг “Иргэд төсвөө хянана” иргэний нийгмийн сүлжээний гишүүн байгууллагууд хөтөлдөг.

ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ БА БИЗНЕСИЙН ОРЧИН

Улс орны хөгжилд улсын төсвийн бодлого маш чухал үүрэгтэй билээ. Сүүлийн жилүүдэд манай улсын төсөв байнга алдагдалтай батлагдаж, урсгал зардлын тэлэлт ч нэмэгдэх болсон. ННФ-аас эрхлэн 2015 оны улсын төсвийн төсөлд хийсэн тойм судалгаагаар төсвийн орлогын нэлээд хэсгийг бүрдүүлдэг уул уурхайн эрдэс баялгийн гол нэрийн бүтээгдэхүүний экспортын тоо хэмжээг хэт өөдрөг төсөөлж орлогыг төлөвлөснөөс үүдэн төсөвт олон удаа тодотгол хийх нөхцөл

байдал үүсч, төсвөөс санхүүжиж буй төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилт удаашрах зэрэг сөрөг үр дагаврууд үүсэх тухай дүгнэлт гарч байсан билээ. ННФ 2004 оноос эхлэн улсын төсвийн бодлого төлөвлөлтийг бусад байгууллага, судлаачидтай хамтран судалж бие даасан, хөндлөнгийн судалгааны мэдээллийг бодлого боловсруулагч, олон нийтэд хүргэж ирлээ. Үүнд, улсын төсвийн төлөвлөлт, Засгийн газрын өр, бизнесийн орчны судалгааг жил бүр хийж байна.

Улсын төсвийн судалгаа, шинжилгээ

Монгол Улсын 2015 оны нэгдсэн төсвийн төсөлд хийсэн тойм судалгаанаас харахад төсвийн орлогын гүйцэтгэлд эрсдэл учирч болзошгүй бөгөөд хөрөнгө оруулалтын дийлэнх хэсгийг төсвөөс гадуурх эх үүсвэрээс санхүүжүүлэхээр тусгасан байна. Засгийн газраас төсвийн орлогыг бодитой төлөвлөж, орлогын бүтцийг сайжруулах хэрэгтэй байна. Мөн төсвийн хариуцлагыг сайжруулахын тулд Хөгжлийн банкны эх үүсвэр, түүний санхүүжилтийг нэгдсэн төсвийн бүрэлдэхүүнд бие даасан төсөв болгон оруулах асуудлыг яаралтай шийдвэрлэх, уг банкны үйл ажиллагааг хянах хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох

шаардлагатай. Түүнчлэн Хөгжлийн банкны эх үүсвэрээр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулах болон гүйцэтгэлд нь тавих хяналтыг сайжруулж, мэдээллийг олон нийтэд ил тод болгох нь чухал. Цаашилбал, орон нутагт төсвийн эрх мэдлийг шилжүүлэхдээ төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сулруулахгүй байх, тусгай сангуудын зарцуулалтын ил тод байдал, хяналтыг сайжруулах, улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын урт ба дунд хугацааны хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Засгийн газар төсвийн болон төлбөрийн тэнцлийн алдагдлаа нөхөх, бүтээн байгуулалтын томоохон төсөл хөтөлбөрүүдээ санхүүжүүлэх зэрэг олон шалтгаанаар гадаад, дотоод эх үүсвэрээс зээл авснаар Засгийн газрын өр үүсдэг. Монгол Улсын хувьд 1990-ээд онд төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжсэнтэй холбоотойгоор Засгийн газар гадаад, дотоод эх үүсвэрээс зээл тусламж авч хөрөнгө босгох болсон. Олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын ангиллаар манай улс 2009 оныг хүртэл бага түвшний орлоготой орны ангилалд багтаж байсан тул олон улсын донор байгууллагууд, хөгжингүй орнуудаас буцалтгүй тусламж, нэн хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлүүдийг авч ашигладаг байсан. Харин 2009 оноос хойш дундаас доогуур орлоготой ангилалд дэвшин шилжсэнээр олон улсын донор байгууллагуудаас арилжааны нөхцөлтэй зээл авах, олон улсын хөрөнгийн зах зээлд төрөл бүрийн бондуудыг гаргах эрхтэй болсон билээ.

Ингэснээр анх 2012 онд Хөгжлийн банкаар дамжуулж нийтдээ 600 сая ам. долларын бонд, Засгийн газар 1.5 тэрбум ам. долларын Чингис бондыг олон улсын хөрөнгийн зах зээлд гаргасан. Эдгээр бондын төлбөрийн нөхцөл нь өмнөх хөнгөлөлттэй зээлүүдтэй харьцуулбал хатуу тул, ирээдүйд өрийн дарамтад орох эрсдэлтэй юм. Нөгөө талаас, эдгээр бондын хөрөнгийн эргэж төлөгдөх хугацаа нь богино, ашигтай төслүүдэд хөрөнгө оруулахын оронд эдийн засгийн хувьд үр ашиг муутай зам болон бусад дэд бүтцийн төслийг санхүүжүүлж байна гэж эдийн засаг судлаачид, олон нийтийн зүгээс шүүмжилж байгаа. Мөн дан ганц уул уурхайн салбараас хэт хамааралтай, эдийн засгаа төрөлжүүлж чадаагүй манай орны эдийн засаг маш түргэн хугацаанд гадаад өрийн дарамтад орох магадлалтай юм. Иймээс Засгийн газрын гадаад өрийн одоогийн нөхцөл болоод ирээдүйн төлвийг судлан холбогдох бодлогын зөвлөмж гаргаж, шийдвэр гаргагч, эрх баригчдад хүргэх шаардлага тулгарч байна.

УЛСЫН ТӨСӨВ БОЛОН ГАДААД ӨРИЙН ДҮН ШИЖИЛГЭЭ



Сангийн яамнаас УИХ-д өргөн барьсан 2015 оны улсын төсвийн төсөлд хийсэн тойм судалгааг бүрэн эхээр нь www.forum.mn сайтаас үзнэ үү.



“Монгол Улсын Засгийн газрын гадаад өр” судалгааны тайлан, илтгэл, судлаачтай хийсэн ярилцлагыг www.forum.mn вэб сайтаас үзнэ үү.

ННФ-аас Засгийн газрын гадаад өрийн талаар бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад ашиглахуйц нэгэн судалгаа хийв. Уг судалгааг ННФ бодлогын судлаачидтай хамтран хийж гүйцэтгэсэн бөгөөд Монгол Улсын Засгийн газрын гадаад өрийн өнөөгийн байдлыг судалж, зөвлөмж боловсруулав. Энэхүү судалгаанд Засгийн газрын гадаад өрийн 2000-2014 оны болон ирээдүйн төлөв

байдлыг 2015 оны төсөв, дунд хугацааны өрийн стратегийн бичигт хэрхэн тусгасан талаар авч үзсэн юм. Мөн Монгол Улсын гадаад өрийг зохицуулж буй одоогийн хууль эрх зүйн орчин, ирээдүйд гарахаар бэлтгэж буй гол хууль, тогтоомжуудын талаар дүгнэж, бодлогын зөвлөмж боловсруулав. Судалгааны дүнг тайлант оны 12 дугаар сард олон нийтэд танилцууллаа.

Төсвийн асуудлаарх уулзалт, хэлэлцүүлэг

Монгол Улсын 2015 оны төсвийн төслийн орлого, зарлага, хөрөнгө оруулалт зэрэг тойм судалгаагаар гарсан дүгнэлтийг бодлого боловсруулагчид, судлаачид, иргэд болон иргэний нийгмийнхний хүрээнд танилцуулах уулзалт хэлэлцүүлэг өрнүүлээ. 2014 оны 11 дүгээр сард “2015 оны улсын төсвийн орлого, зарлагын төлөвлөлт”, “Монгол Улсын 2015 оны төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт”, “Монгол Улсын 2015 оны төсвийн өрийн удирдлага” сэдэвт цуврал хэлэлцүүлэг зохион байгуулагдав.

Хэлэлцүүлгийн үеэр Сангийн яамнаас 2015 оны улсын төсвийн орлого, зарлагын төлөвлөлт, өрийн удирдлага, ННФ-ын санаачилгаар судлаачид төсвийн төлөвлөлтөд хөндлөнгийн, хараат бус тойм дүгнэлт хийснээ тус тус танилцууллаа.

2015 оны төсвийн төсөлд хийсэн шинжилгээ, тойм дүгнэлт, хэлэлцүүлгүүдийн тэмдэглэл, илтгэлүүд, улсын төсвийн төлөвлөлтөд анхаарах асуудлын талаарх мэдээлэл зэргийг www.forum.mn цахим хуудсанд нийтэлж, олон нийтэд хүргэлээ.



“Монгол Улсын Засгийн газрын гадаад өр” болон улсын төсвийн төслийн цуврал хэлэлцүүлэг 2014 оны 11-12 дугаар сард зохион байгуулагдав.



Зураг дээр зүүн гараас: Судлаач Л.Гангэрэл, Улсын төсвийн хэлэлцүүлэгт оолцогчид, ННФ-ын Эдийн засгийн бодлогын хөтөлбөрийн менежер Д.Оюунбадам, Гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал нар.

Хэрэглэгчийн хүлээлтийн индекс

ННФ 2010 оноос эхлэн Санхүүгийн зах зээлийн холбоотой хамтран “Хэрэглэгчийн хүлээлтийн индекс (ХХИ)” судалгааг улирал тутамд хийж байна. ХХИ-ийг хэрэглэгчдийн ирээдүйн болон өнөөгийн санхүү эдийн засгийн нөхцөл байдал, үнийн түвшин, ажил эрхлэлт болон банкны салбарын талаарх хүлээлтийг тодорхойлох зорилготой бүлэг асуултуудаас бүрддэг асуулга дээр үндэслэн тооцдог. Уг индексийг гаргаснаар бизнесийн болон төрийн байгууллагууд хэрэглэгчдийн хэрэглээний

ирээдүйн хандлагын талаар бодит мэдээлэлтэй болж, үүний үндсэн дээр нийт хэрэглэгчдийн хүлээлттэй уялдсан бодитой шийдвэр гаргах боломжтой болдог. Энэхүү индекс нь ирээдүй рүү хандсан, эдийн засгийн чиг хандлагыг тодорхойлох, мөн зах зээлийн ирээдүйн төлвийг таамаглахад ашиглагддаг хамгийн чухал индикатор хэмээн эдийн засагч, бизнесменүүд, төрийн албан тушаалтнуудын дунд хүлээн зөвшөөрөгддөг юм.

ХЭРЭГЛЭГЧИЙН ХҮЛЭЭЛТИЙН ИНДЕКС, СУДАЛГАА



Хэрэглэгчийн хүлээлтийн индекс 2013 оны эцэс гэхэд 174 байсан бол 2014 оны 4-р улиралд 81 болж бууран түүхэн доод түвшинд хүрсэн. Энэ уналт нь Монголын эдийн засагт итгэх иргэдийн итгэл туйлдаа хүртэл муудаж буйг харуулж байна. ХХИ-ийн уналтад гадаадын хөрөнгө оруулалтын бууралт, ам.долларын ханшийн өсөлт зэрэг хүчин зүйл нөлөөлсөн байх талтай.

Хэрэглэгчийн хүлээлтийн индексийн улирал тутмын тайланг www.forum.mn цахим хуудаснаас үзнэ үү.

Бизнесийн орчин

Дэлхийн эдийн засгийн форумас Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан (ДӨЧТ)-г жил бүр эрхлэн гаргадаг бөгөөд ННФ уг байгууллагын түншээр 10 дахь жилдээ ажиллаж байна. Өрсөлдөх чадварын индекс нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зэрэглэл ба индексийг 12 тулгуур үзүүлэлтээр тодорхойлдог юм. Бид тус тайлангийн Бизнесийн байгууллагын удирдах ажилтнуудын судалгааг явуулдаг ба тайлан дахь Монгол Улсын зэрэглэлийн тухай жил бүрийн 9 дүгээр сард танилцуулж, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээж ажилладаг. Тус тайлангийн дүнг улс орнууд анхааралтай авч үзэж, өрсөлдөх чадвараа сайжруулах бодлого, үйл ажиллагаандаа тусгаж хэрэгжүүлдэг байна.


Монгол Улс 2005 оноос энэхүү тайланд нэгдэж, өрсөлдөх чадварын түвшингээ дэлхийн 140 гаруй оронтой харьцуулах боломжтой болсон юм. Судалгаанд хамрагдсанаас хойших хугацаанд манай улс авбал зохих 7 онооноос

3.2-3.9 оноо авсан нь өрсөлдөх чадварын хувьд дорвитой өөрчлөлт гарахгүй байгааг харуулж байна.


Монгол Улс 2014-2015 оны тайлан судалгаагаар 3.8 оноо авч өмнөх онтой харьцуулахад бага зэрэг сайжирснаар судалгаанд хамрагдсан 144 орноос 98 дугаарт жагсжээ. Өнгөрсөн онд манай улс 3.7 оноогоор 107 дугаар байрт орж байсан юм.

Өрсөлдөх чадварын индексээр улс орнуудыг Инновацид тулгуурласан, Үр ашигт тулгуурласан, Заяагдмал нөөцөд тулгуурласан эдийн засагтай гэж хөгжлийн 3 түвшинд хуваан авч үздэг. Манай улс хөгжлийн доод түвшин буюу Заяагдмал нөөцөд тулгуурласан эдийн засагтай улс орноос хөгжлийн 2-р түвшин буюу Үр ашигт тулгуурласан эдийн засагтай түвшин рүү ШИЛЖИЖ БУЙ орнуудын ангилалд багтаж байна.

МОНГОЛ УЛСЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ОНОО,
2005-2014



МОНГОЛ УЛСЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ЗЭРЭГЛЭЛ,
2005-2014



Монгол Улсын хувьд институцийн чанар, дэд бүтэц, санхүүгийн зах зээлийн хөгжил, технологийн бэлэн байдал болон бизнесийн төгөлдөршил гэсэн үзүүлэлтүүдээ дээшлүүлж чадвал Үр ашигт тулгуурласан эдийн засагтай орнуудын ангилалд орж манай улсын өрсөлдөх чадвар сайжрах болно.

Энэхүү өрсөлдөх чадварын индексийн дүн нь засгийн газар, бизнесийн болон иргэний нийгмийн байгууллагуудын дунд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлэхэд зохих хувь нэмэр оруулна хэмээн найдаж байна.

**ДЭЛХИЙН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН
2014-2015 ОНЫ ТАЙЛАН**



Тайланг бүрэн эхээр нь http://www3.weforum.org/docs/WEF_GlobalCompetitivenessReport_2014-15.pdf хаягаар үзнэ үү.

ДЭЛХИЙН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН 2014-2015 ОНЫ ТАЙЛАН: МОНГОЛ УЛС



Эх сурвалж: ДЭЗФ-ын Дэлхийн өрсөлдөх чадварын 2014-2015 оны тайлан, судалгааны дүнгийн дэлгэрэнгүй танилцуулгыг www.forum.mn вэб сайтаас үзнэ үү.

Өрсөлдөх чадварын индексийн тулгуур үзүүлэлтүүдээс институцийн чанар, дэд бүтэц, санхүүгийн зах зээлийн боловсронгуй байдал, зах зээлийн хэмжээ гэсэн 4 үзүүлэлтээр авбал зохих онооны 50 хувьд ч хүрч чадаагүй байна.

Индексийн тулгуур үзүүлэлтийг бүрдүүлдэг 115 дэд үзүүлэлтээс манай улс 140 гаруй орноос 10

гаруй үзүүлэлтээр эхний 50 байрт багтсан нь тэмдэглүүштэй. Эдгээрээс дурдвал, цалин хөлс ба бүтээмж, цалин хөлс тогтоох уян хатан байдал, татварын нийт хувь хэмжээ, хөрөнгө оруулагчийн хамгаалалт, бизнес эхлэхэд шаардагдах журмын тоо, ДНБ-д эзлэх үндэсний хуримтлалын хувь хэмжээ зэрэг юм.

ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИУДЫН ЗАСАГЛАЛ

Уул уурхайн компаниудын засаглал

Байгалийн нөөц баялгаа ашиглан эдийн засгаа хөгжүүлэх бодлогыг төрөөс баримталж байгаа өнөө үед байгалийн баялгийн үр шимийг зөв, оновчтой захиран зарцуулж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх явдал чухал юм. Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой уул уурхайн компаниуд нь стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд газруудын дийлэнхийг

эзэмшин олборлолт явуулж, улс орны эдийн засагт томоохон хувь нэмэр оруулж байгаа боловч тэдгээр компанийн засаглалыг сайжруулж, үр өгөөжийг нэмэгдүүлэх нь хойшлуулшгүй зорилт болоод байна. Төрийн болон төрийн өмчийн оролцоотой компаниудын засаглал сайн байх нь компанийн үр ашгийг нэмэгдүүлж, эрсдэлийг удирдан зарлагыг бууруулж, нийтийн баялгийг үрэн



таран хийхээс сэргийлж, удаан хугацаанд тогтвортой ажиллах, хөрөнгө оруулалт татан бизнесээ өргөжүүлэх боломж олгох төдийгүй улс орны хөгжил тогтвортой, зөв явахад чухал нөлөө үзүүлэх болно.

Энэ чиглэлийн ажилд хувь нэмэр оруулах зорилгоор ННФ 2014 онд Уул уурхайн яамтай хамтран төрийн өмчит уул уурхайн компаниудын засаглалын өнөөгийн түвшин, цаашид сайжруулах арга хэмжээг тодорхойлох засаглалын үнэлгээний судалгаа хийгээд байна. Монгол Улсын эдийн засагт томоохон нөлөө үзүүлдэг уул уурхайн есөн компанийг хамарсан энэхүү судалгаагаар төрийн өмчит уул уурхайн компанийн засаглалын ерөнхий түвшин хэт доогуур байгаа нь харагдав. Ихэнх компани авбал зохих дээд үнэлгээний гуравны нэгийг буюу засаглалын түвшин 100 хувь байхаас 9.7-24.0 хувьтай гарсан нь Азийн орнуудын төрийн өмчит компанийн засаглалын түвшинтэй харьцуулахад даруй 1.5-2.5 дахин бага байв.

Судалгааны дүнгээс харахад төрийн өмчийн уул уурхайн компаниуд засаглалын чиглэлээр гарсан нийтлэг хууль, дүрэм журмыг төдийлөн сайн хэрэгжүүлэхгүй байгаа нь ажиглагдав.

Тухайлбал, хуулийн дагуу ил болгох мэдээлэл тавигдаагүй, төлөөлөн удирдах зөвлөл болон хувьцаа эзэмшигчдийн хурал, чухал хэлцлийг хуулийн дагуу явуулдаггүй зэрэг засаглалын чанарыг бууруулж буй нийтлэг дутагдал харагдаж байв.

Засаглалын үнэлгээнд оролцсон компани тус бүрийн тайланг тухайн компанийн удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх удирдлагуудын оролцоотойгоор хэлэлцэн үр дүнг хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээлээ.



Төрийн болон төрийн өмчит уул уурхайн компаниудын засаглалын үнэлгээг холбогдох талуудын оролцоотойгоор хэвлэл мэдээллээр дамжуулж хэлэлцүүлэг өрнүүлэв.

Дээр хэлэлцүүлгийн үеийн зарим зургийг харуулав.

Нээлттэй Нийгэм Форум, 2014 оны 9 дүгээр сарын 29.

Мөн түүнчлэн судалгааны дүнд үндэслэн төрийн өмчит уул уурхайн компанийн засаглалыг сайжруулах талаар төр болон компанийн зүгээс авч болох арга хэмжээг тусгасан Зөвлөмж боловсруулан холбогдох талуудад хүргүүлээд байна. Цаашдаа энэхүү засаглалын үнэлгээний дүгнэлт зөвлөмжид үндэслэн төрийн өмчит

болон төрийн өмчийн оролцоотой компанид төрийн төлөөллийг хэрэгжүүлэх чиглэлээр хууль тогтоомжийг боловсронгуй болгох, засаглалын түвшингээ бие даан тогтмол үнэлж, сайжруулах чиглэлээр компаниудын чадавхыг бэхжүүлэх ажлуудыг холбогдох талуудтай хамтран хэрэгжүүлэх юм.

Эрчим хүчний компаниудын засаглал

Монгол Улсын эрчим хүчний салбар улсын төсвөөс санхүүжиж, үйл ажиллагааг бараг бүхэлд нь төр хариуцдаг бөгөөд сүүлийн жилүүдэд энэ салбар асар их хөрөнгө оруулалт, гадаадын зээл тусламжаар тэтгэгдэж иржээ. Улс орны эдийн засаг, нийгмийн хөгжилд нэн чухал үүрэгтэй энэ салбарын засаглалын үнэлгээг анх ННФ 2012 онд хийж салбарын нэлээд асуудлыг ил тод хөндөн бодлого боловсруулагчид, салбарын мэргэжилтнүүд, төрийн өмчит компанийн болон иргэдийн төлөөллийг оролцуулан өргөн хүрээний хэлэлцүүлэг өрнүүлсэн юм. Энэхүү хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмжид үндэслэн юуны өмнө төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой эрчим хүчний компаниудын Засаглалын түвшинг үнэлэх судалгааны ажил эхлүүлээд байна. Эрчим хүчний салбарын төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулахад ерөнхийд нь нийтлэг байдлаар ярьж бичих нь үр дүн муутай. Харин тодорхой компанийн засаглалыг сайжруулахаас эхэлж, энэ нь цаашид бусдад үлгэр дуурайлал болж, нийтийг хамруулах нь илүү үр дүнд хүрэх юм. Иймээс ННФ судлаачидтай хамтран манай улсын эдийн засагт чухал ач холбогдол бүхий төрийн өмчийн эрчим хүчний

компаниудын засаглалын өнөөгийн түвшинг тодорхойлж, түүнийхээ үндсэн дээр тэдгээр компанийн засаглалыг сайжруулах Зөвлөмж гарган бодлого боловсруулагчид, компанийн удирдлагад хүргэхээр ажиллаж байна.

Энэхүү судалгаагаар эрчим хүчний салбарын төрийн өмчит 13 компанийн засаглалын түвшин ямар байгааг тодорхойлох юм. Мөн компани тус бүрийн засаглалыг сайжруулах талаар төр болон тухайн компанийн зүгээс хийх үйл ажиллагааг засаглалын бүрэлдэхүүн хэсэг бүрээр тодорхойлсон Зөвлөмж гаргаж тайланд хавсарган судалгаанд хамрагдсан компаниуд болон холбогдох төрийн байгууллага, бодлого боловсруулагчдад хүргүүлэхээр ажиллаж байна.


Бид 2011 оноос Дэлхийн нөөцийн институт (www.wri.org)-ээс санаачлан байгуулсан Цахилгаан, эрчим хүчний засаглалын санаачилга (electricitygovernance.wri.org)-ын гишүүн байгууллагаар ажиллаж, 2014 онд уг санаачилгын олон улсын түншүүдийн хуралд оролцон, эрчим хүчний засаглалын чиглэлээр хэрэгжүүлж буй олон улсын туршлагатай

танилцлаа. Хуралд 10 гаруй орны төлөөлөгчид оролцож, эрчим хүчний хэрэгцээг хангахад тулгарч буй засаглалын сорилтууд, цахилгаан үйлдвэрлэл, дамжуулалт, түгээлтийн системийн

ирээдүйн талаарх судалгаа, нөлөөллийн арга зүй, санаачилгын зүгээс цаашид хийх ажлууд сэдвийн дор хэлэлцүүлэг өрнүүллээ.



Цахилгаан эрчим хүчний засаглалын санаачилгын олон улсын түншүүдийн хурал, Тайланд, Бангкок, 2014 оны 10 дугаар сар.



БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН ХӨТӨЛБӨР

Тэгш хамрагдах боловсролын чиглэлээр дагнан ажиллах төрийн бус байгууллагуудын сүлжээ байгуулагдаж үйл ажиллагааны стратегиа боловсрууллаа.

Бага насны хүүхдийн хөгжлийн явцыг үнэлэх арга зүй боловсруулагдаж, тэднийг хөгжүүлэх арга ажиллагааны ном, гарын авлагууд орчуулагдаж гарлаа.

Залуучуудыг хүчирхийллээс сэргийлэх талаар судалгаа хийж цаашид явуулах үйл ажиллагааны чиглэлээ тодорхойллоо.

ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛ

Монгол Улс хүүхэд бүрт суурь боловсрол эзэмшүүлэх зорилт тавьж, улсын төсвийн зардлын 20-иос доошгүй хувийг боловсролын салбартаа зарцуулж байна. Нийгэм, эдийн засгийн шилжилт ид өрнөж байсан 1990-ээд онд нэлээд буурсан сургуулийн хамран сургалт одоо эргээд бүх нийтийн шахуу (бараг 100 хувь) үзүүлэлтэд хүрээд байгаа албан ёсны статистик мэдээ харуулж байгаа юм. Мөн 2012 оноос сургуульд хамруулаад зогсохгүй хүүхэд бүрийг хөгжүүлэх зорилт дэвшүүлж, багш, сургуулиуд зөвхөн хичээлийн агуулгаар ажлаа хязгаарлалгүй, хүүхдийн авьяас, сонирхлыг нээх, хөгжүүлэхэд анхаарч байна. Улмаар сургуульд сурч байгаа хүүхэд мэдлэг эзэмшээд зогсохгүй чөлөөт цагаараа өөрийгөө хөгжүүлэн, төрөл бүрийн ур чадвар, нийгмийн харилцааны туршлага олж авч байна.

Харамсалтай нь, зарим хүүхэд, түүний дунд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд суурь боловсролд хамрагдах эрхээ эдэлж чадахгүй боловсролын үйлчилгээнээс гадуур үлдсээр байгаа юм. Нэг жишээ дурдахад, 2010 оны хүн ам, орон сууцны тооллогын дүнгээр 6-14 насны нийт хүүхдийн 97 хувь нь, энэ насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дөнгөж 67 хувь нь сургуульд суралцаж байжээ. Боловсрол эзэмшсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 7 хүрэхгүй хувь нь суурь боловсролтой (9 дүгээр анги дүүргэсэн), үлдсэн 93 хувь нь бага боловсролтой байна. Цаашилбал, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын талаар найдвартай, баталгаатай мэдээлэл алга байна. 2010 оны



Судалбар зураг: Боловсролд тэгш хамрагдах Гэрэл зургийг сэтгүүлч Б.Мөнхгэрэл

хүн амын тооллогоор суурь боловсролын нас (6-14 нас)-ны хөгжлийн бэрхшээлтэй нийт 7500 орчим хүүхэд тоологдсон байхад боловсролын албан ёсны мэдээнд 2010-2011 оны хичээлийн жилд бага, дунд боловсролд хөгжлийн бэрхшээлтэй 18300 орчим хүүхэд хамрагдаж байгаа дүн гарчээ. Уг зөрүүг мэдээлэл цуглуулах арга зүйн ялгаатай байдлаар тайлбарладаг ч энэ нь төрийн болон төрийн бус байгууллага, эцэг эхчүүдийн хооронд үл итгэлцэл үүсгэж хамтын ажиллагаанд саад болж байдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын үйлчилгээг хэрхэн оновчтой зохион байгуулах асуудлаар нийгэмд өөр өөр байр суурь байна. Нэмэлт дэмжлэг, туслах арга хэрэгсэл, арга зүйн тохируулга хийх замаар энгийн ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургах нь нийгэм, хувь хүнд илүү өгөөжтэй гэсэн итгэл үнэмшилтэй хүмүүс байна. Гэтэл бас сургалтын туслах арга хэрэгсэл болон тодорхой хөгжлийн бэрхшээлээр мэргэшсэн мэргэжилтнүүдийг нэг дор төвлөрүүлсэн тусгай сургуулиудыг дэмжих хэрэгтэй гэж үзэх хүмүүс байна. Боловсролын тухай хуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд энгийн ерөнхий

боловсролын сургуульд сурч болох тухай заалт байгаа ч мөн тусгай хэрэгцээт боловсролыг тусгай сургуулиар олгох тухай заалт оржээ. Ингэхлээр энэ нь эцэг эх, багш нар хоорондоо ярилцаж ойлголцох асуудал төдийгүй эрх зүйн хувьд нэгмөр зохицуулах шаардлагатай асуудал болж байна.

ННФ 2014 онд боловсролын салбарын оролцогч талуудын хоорондын харилцан яриа, хамтын ажиллагааг бэхжүүлэх, бодлого боловсруулах үйл явцад мэдлэг, мэдээлэлтэй оролцох иргэний нийгмийн чадварыг хөгжүүлэхэд анхаарч ажиллалаа. Бид энэ онд боловсролын салбарт идэвхтэй ажиллаж байгаа иргэний нийгэм, эцэг эхийн байгууллага, төрийн захиргаа болон төрийн үйлчилгээний байгууллага нэг дор цугларч, боловсролын бодлого, түүний хэрэгжилтэд өгөх үнэлгээ дүгнэлтээ хэлэлцэх, бүтээлчээр шүүмжлэх, өөрсдийн саналыг дэвшүүлж ярилцах нөхцөл бололцоо бий болгоход анхаарч, үүний үр дүнд боловсролын салбарт бодлогын түншлэл, хамтын ажиллагааг бэхжүүлэхийг зорив. Ингэхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын асуудлыг онцгойлон анхаарч ажиллалаа.

ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛ

Хүний эрх, эрх тэгш байх зарчим, бие даан амьдрах эрхийг хангах зорилгоор дэлхий нийтээрээ тусгай сургуулиас татгалзаж, тусгай хэрэгцээт боловсролыг нэмэлт болон тохируулах үйлчилгээтэй энгийн сургуулиар олгож, үүнийг тэгш хамруулах боловсрол гэж нэрлэдэг. Энэ хандлагыг хүүхдийн сурч боловсрох эрхийг хангахдаа нийгэмших, ялгаварлан гадуурхагдахгүй байх зэрэг бусад эрхийг нь дордуулаагүй гэсэн үндэслэлээр НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцид дэмжжээ.

Боловсролын судалгаа шинжилгээ

ННФ 2014 онд боловсролын бодлогын асуудлаар судалгаа, шинжилгээ гүйцэтгэхийн зэрэгцээ төрийн болон төрийн бус байгууллагыг хамруулсан форум хэлэлцүүлэг зохион байгуулж, тэгш хамруулах боловсролын талаарх иргэний нийгмийн мэдлэгийг нэмэгдүүлэх сургалт, хэрэлцүүлэг хийлээ. Үүний зэрэгцээ энэ салбарт идэвх санаачлагатай ажиллаж байгаа иргэний нийгмийн байгууллагын хөгжлийг дэмжих, стратегийн зорилтуудаа тодорхойлж хэрэгжүүлэхэд нь санхүүгийн болон арга зүйн туслалцаа үзүүлж байна.

2014 оны үйл ажиллагааны үр дүнд Их Британийн нэр хүнд бүхий хөгжлийн судалгааны байгууллага болох Хилийн чанад дахь хөгжлийн хүрээлэнтэй хамтран хийсэн Монголын боловсролын 1990 оноос хойших хөгжлийн үйл явцад үнэлгээ өгөх тойм судалгаа хийлээ (тайланг бүрэн эхээр нь www.forum.mn сайтаас үзэх боломжтой). Энэ судалгаагаар Монгол Улс шилжилтийн үеийн хямралыг даван туулж, сургуулийн хамран сургалт, цаашилбал ерөнхий боловсрол дүүргэн, дээд болон мэргэжлийн боловсролд үргэлжлүүлэн сурч байгаа хүүхдийн тоогоор Төв Азийн бүсдээ тэргүүлэх түвшинд хүрч чадсан амжилтыг онцлов. Үүнд хүүхдээ боловсролтой болгох эцэг эхчүүдийн хүсэл эрмэлзэл, төрөөс боловсролын салбарт зарцуулж байгаа багагүй хэмжээний хөрөнгө төсөв, ерөнхий боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн төсөв санхүүгийн бодлогын үр өгөөж, мөн гадаадын хандивлагчдын дэмжлэг зэрэг хүчин зүйл нөлөөлжээ. Гэхдээ өнгөрсөн хугацаанд төдийлөн анхаарч чадаагүйгээс үргэлжилсээр байгаа хүндрэл, мөн нийгэм, хүн амзүйн өөрчлөлтийн улмаас шинээр үүссэн хэд хэдэн бэрхшээл байгаагийн дотор сургалтын чанар сул, агуулга нь хөдөлмөрийн зах зээлийн хувьсан өөрчлөгдөж байгаа хэрэгцээнд

нийцэхгүй, мөн хот, хөдөөгийн сурагчдын сурлагын амжилт нэлээд ялгаатай байгаа зэрэг асуудал багтаж байна. Боловсролын салбарын тэгш байдлыг нэмэгдүүлэхэд бүх нийтийг хамарсан бодлого өгөөжтэй байж болох ч зорилтот бүлэг, ялангуяа үндэсний цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боловсролын хэрэгцээг хангахад чиглэсэн зорилтот арга хэмжээ зайлшгүй шаардлагатай гэж зөвлөсөн нь манай улсад ч хамаатай.

Бид 2014 онд тэгш хамруулах боловсрол, тусгай хэрэгцээт боловсролын сэдвээр янз бүрийн санал бодол, байр суурийг сонсох уулзалт семинар, тэгш хамруулах боловсролын талаар олон улсад бий болсон мэдлэг, туршлагыг

СУДАЛГАА: МОНГОЛ УЛСЫН БАГААС ДЭЭШ ШАТНЫ БОЛОВСРОЛ

УНАЛТААС СЭРГЭЛТЭД:
МОНГОЛ УЛСЫН БАГААС
ДЭЭШ ШАТНЫ БОЛОВСРОЛ

- 1. 2013 онд 6-11 насны хүүхдийн 100% нь ангийн сургалтад оролцож байна. Энэ нь 2010 онд байсан 97,7 хувийн өсөлт юм.
- 2. 6-11 насны хүүхдийн уншигч хувийн өсөлт нь ангийн сургалтын чанартай холбоотой байна.
- 3. Ангийн сургалтын чанартай холбоотой өөрчлөлтүүд нь ангийн сургалтын үр дүнд нөлөөлж байна.
- 4. Хүүхдийн сургалтын чанартай холбоотой өөрчлөлтүүд нь ангийн сургалтын үр дүнд нөлөөлж байна.

developmentprogress.org

дамжуулах, өөрсдийн туршлагыг солилцох цуврал сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, иргэний нийгмийнхнээс гадна төрийн захиргааны байгууллагын мэргэжилтэн, багш бэлтгэх болон багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын байгууллага, тусгай сургуулийн багш нарын оролцоог хангахыг хичээлээ. Эдгээр үйл ажиллагааны үр дүнд 2014 оны эцсээр 14 төрийн бус байгууллага нэгдэн Тэгш хамруулах боловсролын иргэний нийгмийн сүлжээ байгуулж, 2 өдрийн семинараар тулгамдаж буй асуудлууд, сүлжээний хүрээнд баримталж ажиллах зарчим, 2015 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, чадавх бэхжүүлэх хэрэгцээ, мэдлэг мэдээллийн эх сурвалж зэргээ тодорхойлсон сүлжээний стратегийг гарган, ирэх онд хамтран ажиллах бэлтгэлээ хангаад байна.

2014 оны онцлох өөр нэг үйл ажиллагаа бол “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол” сэдэвт форум байлаа. Форумд багш бэлтгэх болон багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын байгууллагын эрдэмтэн багш, тусгай сургуулийн багш, захирал, төрийн бус байгууллагын судлаачид илтгэл тавьж, эцэг эх, иргэний нийгмийнхэн, тусгай болон энгийн сургуулийн удирдлага, багш, нийгмийн ажилтан, нийслэл, дүүргийн боловсролын хэлтсийн мэргэжилтэн, сайн дурын ажилтан залуучууд, судлаач 90 гаруй хүн санал бодол, туршлага, шүүмжээ хуваалцаж оролцлоо. Форумгаар байр суурийн ялгаа, гүнзгийрүүлж судлах асуудал, тодорхой байгууллагын бий болгоод байгаа тэргүүн туршлага зэрэг олон сонирхолтой асуудал хөндөгдсөн нь



Дохионы хэлний цагаан толгой.

дараа жилийн ажлаа төлөвлөхөд бидэнд нэн тустай байлаа. Илтгэлүүд нь тэгш хамруулах боловсролын талаарх ойлголт хандлага, тусгай болон тэгш хамруулах сургууль, цэцэрлэгийн дэвшилтэт туршлага, иргэний нийгэм, тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн байр суурийг тусгасан тул Монголын тэгш хамруулах боловсролын өнөөгийн түвшин, нөхцөл байдлыг харуулж чадсан юм. Илтгэлүүдийг эмхэтгэн, казак болон англи хэл рүү орчуулаад, хэвлэн тараахаар төлөвлөж байна.

Бодлогын үйл явц дахь иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, дотоодын чадавхыг нь бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх уламжлалт чиглэлээ энэ жил ч үргэлжлүүлэн баримталаа. Боловсрол, хөгжлийн бэрхшээлийн асуудлаар хамгийн өргөн төлөөлөл, олон жилийн туршлагатай Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийн холбоо ТББ нь зөвлөгөө, мэдээллийн

төв болж үйл ажиллагаагаа өргөжүүлэхийн зэрэгцээ төрийн үйл ажиллагаанд мониторинг хийх арга зүйд суралцан, нөлөөллийн чадавхаа бэхжүүлэх зорилго тавьж, ННФ-ын санхүүгийн болон арга зүйн дэмжлэгийг авч ажиллаж байна. Энэ нь нэг жилийн хүрээгээр хязгаарлагдахгүй байгууллагын хөгжлийн үйл явц тул 2014 онд мэдээллийн үйлчилгээг хүргэх бэлтгэлээ хангаж, өнөөдрийн байдлаар ашиглах боломжтой үйлчилгээ болон үйлчилгээ үзүүлэгчдийн лавлагаа боловсруулж, автомат хайлтын систем бүхий мэдээллийн бааз бий болгоод байгаа ба холбооны гишүүн эцэг эхчүүдээ лавлагаа, мэдээллийн үйлчилгээ үзүүлэхэд бэлтгэн сургаж байна. 2015 онд мэдээлэл, лавлагааны үйлчилгээгээ туршилтаар хэрэгжүүлэхийн зэрэгцээ дүн шинжилгээ, бодлогын нөлөөллийн чадавхаа бэхжүүлэх үүднээс мониторинг хийх юм.



Дээрх зурагт зүүн гар талаас: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эрх, боловсролын чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагын ажилтнууд, ННФ-ын Боловсрол, нийгмийн хөтөлбөрийн менежер А.Гэрэлмаа, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг, эхийн холбооны гишүүд.

БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ

Хөгжлийн хоцрогдол, хөгжлийн бэрхшээлийг аль болох эрт илрүүлж, хөгжүүлэн дэмжиж чадах юм бол хөгжлийн бэрхшээлтэй хүн бие даан амьдарч, нийгэм, эдийн засгийн амьдралд оролцох чадавх, сэтгэл зүйн бэлтгэлтэй болж, тэр хэрээр нийгмийн халамжийн ачаалал буурч, хөгжлийн бэрхшээлтэй хүний амьдралын чанар, сэтгэл хангалуун байдал нэмэгдэнэ.

Дэлхийн олон оронд хүүхдийн хөгжлийн явцыг төрсөн цагаас нь ажиглан, хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг бага насанд нь илрүүлэн, хөгжүүлэх үйлчилгээг төрөөс үзүүлдэг. Монголд одоо хэрэгжиж байгаа оношид суурилсан эмчилгээ, сэргээн засалтын үйлчилгээнээс ялгаатай энэхүү шинэ үйлчилгээг бий болгох шийдвэрийг 2013 онд гаргаж, УИХ-аар баталсан хуулийн өөрчлөлтөөр хэрэгжүүлж

эхэлсэн ба боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд нарын хамтарсан тушаалаар Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын комиссыг байгуулаад байна. ННФ 2014 онд нийгмийн салбарын гурван яамтай байгуулсан Хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд энэхүү Комиссын тогтолцоог бэхжүүлэн, агуулга, арга зүйн дэмжлэгээр хангах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Бага насны хүүхдийн хөгжлийн дэмжих үйлчилгээний шинэ тогтолцоог ажиллуулахад Монгол Улсад бэлэн мэдлэг, өмнөх үеийн туршлага байхгүй тул тул бид гаднаас мэдлэг, туршлага дамжуулж авах, гадны мэргэжилтэн урьж авчран сургалт хийлгэх, англи хэлнээс эх сурвалж материал орчуулж эцэг эх,



Зүүн гар талаас: Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих сургалтад оролцогчид, АНУ-ын Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний мэргэжилтэн М. Моран Нээлттэй Нийгэм Форум, 2014 оны 10 дугаар сар.

мэргэжилтнүүдэд хүргэхийн зэрэгцээ дотоодын төрийн бус байгууллагуудын сонирхлыг дэмжин, татан оролцуулах чиглэлээр ажиллалаа.

2014 оны 2 дугаар сард АНУ-ын Миннесота мужийн их сургуулийн дэмжлэгтэйгээр туршлага судлах аялал зохион байгуулж, БШУЯ-ны тэгш хамруулах боловсролын мэргэжилтэн, Хүүхдийн төлөө үндэсний газар болон нийслэл, дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар, төвийн мэргэжилтэн, иргэний нийгмийн болон эцэг эхийн төлөөллийг хамрууллаа. Танилцах аяллын үеэр Миннесота мужийн бага насны хүүхдийн хөгжлийн үнэлгээний тогтолцоо, мөн тусгай хэрэгцээт боловсролын үйлчилгээ, зохион байгуулалттай танилцаж, багш, мэргэжилтнүүдийн өдөр тутмын ажлыг ажиглан судлахын зэрэгцээ мужийн захиргаа, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боловсролын асуудал хариуцсан удирдлагуудтай ярилцаж, энэхүү үйлчилгээг хэрхэн удирдан зохион байгуулах, санхүүжүүлэх талаар мэдлэгтэй боллоо. Мөн Миннесота мужийн их сургууль болон хувийн их сургуулийн тусгай хэрэгцээт боловсролын багш бэлтгэх хөтөлбөртэй танилцаж, эцэг эхийн холбооны мэдээлэл лавлагааны Пейсер төвд зочиллоо. Сургалт, мэдээлэл, туршлага олгох үйл ажиллагааг хослуулсан энэ аялал нь АНУ-ын нэгэн мужийн туршлагыг Монголын нөхцөлтэй харьцуулан, ойлголтоо бэхжүүлэхийн зэрэгцээ энэхүү шинэ төрийн үйлчилгээг зохион байгуулахад анхаарах асуудлуудыг олж харахад тус болсон юм.

2014 оны дундуур байгуулагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын Комисст дээрх аяллаар олж авсан мэдлэг, мэдээллийг дамжуулах, бусад эх сурвалжаас авсан арга зүйн мэдээллийг дамжуулах ажлыг цуврал сургалт семинарын хэлбэрээр зохион байгууллаа. Сэргээн засалтын үндэсний төвийн дэргэд байгуулагдсан уг

Комиссын гишүүд сургалтад маш идэвхтэй оролцож, цаашид ч хамтран ажиллахад нээлттэй байгаа ба хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлтийг хийгээд байна. 2015 онд бид хүүхдийн хөгжлийн явцыг үнэлэх баталгаатай, найдвартай, шинжлэх ухааны үндэслэлтэй үнэлгээний хэрэглэгдэхүүн орчуулах, Монголд туршин нийцүүлэх ажлыг зохион байгуулах юм.

2014 оны 10 дугаар сард бид гадаадын зөвлөхийг Монголд урьж, шинээр бий болох үйлчилгээний мөн чанар, онолын үндэслэл, бүтэц тогтолцоо, ашигладаг арга хэрэглэгдэхүүний тухай мэдлэг олгох сургалт хийлээ. АНУ-ын Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний мэргэжилтэн М. Моран, Нээлттэй Нийгэм Сангуудын Боловсролыг дэмжих хөтөлбөрийн ахлан мэргэжилтэн К.Лапхам нарын удирдан явуулсан 3 өдрийн сургалтад Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын комиссын төв болон дүүргийн салбарын мэргэжилтэн, хүүхдийн эмч, иргэний нийгмийн судлаач 40 гаруй хүн хамрагдаж, шинэ тогтолцооны зорилго, үйлчилгээний талаар тодорхой мэдээлэл, нарийн мэдлэгтэй болсон юм. Сургалтад ашигласан гарын авлага, танилцуулах материалыг эмхэтгэн, хэвлэмэл бүтээгдэхүүн болгож энэ салбарын мэргэжилтэн, захиргааны ажилтнуудад тараах тухай оролцогчдын саналыг хүлээн авч, 2015 онд энэхүү гарын авлагыг хэвлэн, Комиссын төв болон аймаг, дүүргийн салбаруудад хүргэх, олон нийтийн хүртээл болгохоор төлөвлөөд байна.

Бага насны хүүхдийн хөгжлийн явц, хөгжүүлэх арга ажиллагааны талаар унших материал нэн дутагдалтай байгаа тул бид 2015 онд хоёр төрлийн хэвлэмэл материал боловсруулан гаргахаар ажиллаж байна. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас албан ёсны зөвшөөрөл авч бодлого, арга зүйн хэлэлцүүлэгт ашиглаж

болох “Хүүхдийн хөгжил ба хөгжлийн бэрхшээл” нэртэй асуудал хөндсөн тайланг орчуулж байна. Мөн Монголын багш, эцэг эхийн холбоо ТББ-ын дэмжлэгтэйгээр “Бага насны хүүхдийн хөгжил: Эцэг эхийн мэдэх ёстой зүйл” мэдээллийн гарын авлага бэлтгэж байна.

Бага насны хүүхдийн хөгжлийн энэ салбарт нэмэлт хүч, мэдлэг, мэдээлэл нэн шаардлагатай байгаа тул энэ чиглэлээр мэдлэг, туршлагатай төрийн бус байгууллагуудыг татан оролцуулах стратегийг баримталж байна. 2014 онд Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг

төрийн бус байгууллага нь ННФ-ын тэтгэлгээр хүүхдийн хөгжлийн явцыг үнэлэх арга зүйг боловсруулах ажлыг манлайлан ажиллаж байна. 2004 оноос Бага насны хүүхдийн хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлж, цэцэрлэгийн багш нарын арга зүйг сайжруулах, эцэг эхийн мэдлэгийг нэмэгдүүлэх чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж, багагүй туршлага хуримтлуулсан байгууллага юм. 2015 онд энэ байгууллага Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн Комисстой хамтран үнэлгээний хэрэглэгдэхүүн орчуулах, турших, сургалт хийх ажлыг гүйцэтгэх юм.

СҮЛЖЭЭНИЙ СТРАТЕГИ БОЛОВСРУУЛАХ СЕМИНАРЫН ҮЕЭР БАГУУДЫН ХИЙСЭН ДАСГАЛ АЖИЛ



Сүлжээ яагаад, юуны төлөө ажиллах ёстой вэ? (итгэл үнэмшил, үнэт зүйлс, сэдэл)



Сүлжээ хэрхэн ажиллах вэ? (үйл ажиллагааны чиглэл, зорилтууд)



Ямар үр дүнд хүрэхээр сүлжээ ажиллах ёстой вэ? (алсын хараа/ эрхэм зорилго)

ЗАЛУУЧУУДЫН ДУНДАХ ХҮЧИРХИЙЛЛИЙГ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ

Нээлтэй Нийгэм Форум 2014 оноос залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх бодлого, стратегийн суурийг тавих хэтийн зорилготой шинэ хөтөлбөр эхлүүлээ. Монголд энэ чиглэлийн судалгаа цөөн, албан ёсны тоон мэдээлэл байхгүй тул тодорхой орон нутагт кейсийн судалгаа хийх замаар эхний ээлжинд баримт, нотолгоо цуглуулж залуучууд, өсвөр насныхны дунд гарч байгаа зөрчил, тэдгээрийн шалтгаан, нөхцөлийг тодорхойлох, олон улсын туршлага судлахад анхаарлаа хандууллаа. Судалгааг хэрэгжүүлэхдээ энэ асуудалд иргэний нийгмийн байгууллагуудын анхаарлыг татах, сонирхсон байгууллагын чадавхыг бэхжүүлэх стратеги баримталж, санал солилцох 2 удаагийн уулзалт, кейсийн судалгааны арга зүйн сургалт хийлээ. Улмаар төслийн уралдаанаар шалгарсан 5 төрийн бус байгууллагын Налайх, Баянзүрх дүүргийн алслагдсан хороо, МУИС-ийн дотуур байр, Архангай аймгийн төв зэрэг газар нутаг, мөн хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын дунд кейсийн судалгааны тайлан гараад байна. Мөн тухайн асуудалд их дээд сургуулийн багш нарын анхаарлыг татах, цаашдаа сургалтын хөтөлбөртөө энэ асуудал, агуулгыг багтаах ажлын эхлэлийг тавих зорилгоор нийгмийн эрүүл мэндийн сургуулийн багшийг арга зүйн зөвлөхөөр

авч ажиллуулаа. 2015 онд судалгааны дүнд түшиглэн олон нийт, холбогдох мэргэжлийн хүмүүст мэдээлэл хүргэх үйл ажиллагаа зохион байгуулахын зэрэгцээ олон улсын туршлагыг ашиглан хүчирхийллийг бууруулах, урьдчилан сэргийлэх загвар хөтөлбөр хэрэгжүүлснээр бодит туршлага бий болгож, бодлогын нөлөөллийн ажил хэрэгжүүлэх юм.

2014 онд хийсэн кейсийн судалгаагаар өсвөр насныхан, залуучуудын дунд дээрэлхэх, дарамтлах, мөнгө, гар утас дээрэмдэх, бүлгээрээ зодолдох тохиолдлууд илэрчээ.

- Баянзүрх дүүргийн алслагдсан хороонд өдрийн цагаар эцэг эх нь ажил хийх, ажил хөөцөлдөхөөр хотын төв ордог тул хараа хяналтгүй болох үед, тухайн орчинд байгаа Христийн 3 сүмээс өөр чөлөөт цагаараа очих газар алга байна. Улмаар ахлах ангийн сурагчдын дунд мөнгө, гар утас дээрэмдэх, зодоон хийх явдал гардаг нь сүлжээгээр тоглох, нэгнийдээ нийлж архидах зэрэгтэй холбоотой нь ажиглагджээ.
- Оюутны байранд гарч байгаа дарамтлах, мөнгө нэхэх явдал нь оны ялгаанаас үүдэлтэй дээрэлхэх сэдэлтэй холбоотой гэж тайлбарлажээ.

- Налайх дүүргийн ахлах ангийнхны дунд гарч байгаа дээрэлхэх, дарамтлах явдал нь ихэнхдээ эрх мэдлээ харуулах гэсэн хувь хүний болон бүлэг хоорондын зөрчлөөс үүдэлтэй гэж дүгнэжээ. Заримдаа монгол, казах хүүхдүүдийн хооронд, мөн сургуулийн болон МСҮТ-ийн сурагчдын хооронд зөрчил гарч байгаа нь ажиглагдсан ч тийм ч ноцтой биш бололтой.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс олон нийтийн орчинд хүчирхийллээс илүүтэй ялгаварлан гадуурхалтад их өртдөг гэсэн дүн гарсныг цааш нарийвчлан судлах хэрэгтэй.

Судалгаагаар өсвөр үе, залуучуудыг гэмт хэргийн зам руу хөтлөх хүчин зүйл гараагүй ч Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, АНУ-ын Өвчлөлийг хянах төв зэрэг нэр хүнтэй байгууллагуудын анхаардаг зүйлс илэрлээ. Хамгийн ноцтой нь ахлах ангийн сурагчид чөлөөт цагаараа очих газар, хамрагдах үйл ажиллагаа байхгүйн улмаас хэсэг бүлгээрээ сэлгүүцэх, нэгнийдээ цуглаж архидах, бусад бүлэгтэй сөргөөцөлдөх зэргээр цагийг өнгөрөөж байгаа ба яваандаа нэг нь “атаман” болж, бүлгийн зохион байгуулалттай болох

магадлалтай байгаа нь санаа зовоох асуудал юм. Ахлах ангийнхан чөлөөт цагаа архидах, сүлжээний тоглоом тоглох зэрэг мөнгө шаардах хэрнээ хөгжүүлэх үр нөлөөгүй зүйлд зарцуулж байгаа нь олон улсын судалгаагаар хүчирхийлэл үйлдэх, хүчирхийлэлд өртөх эрсдэлт хүчин зүйл юм. Хоёрдугаарт, энэ бүлгийн дотор гарч байгаа хүчирхийлэл нь голдуу үе тэнгийн нэг хүйсийн хүүхдүүдийн дунд, мөн заавал гэрчтэйгээр үйлдэгдэж байгаа (бүлгээр, эсвэл ажиглагчдын нүдэн дээр)-аараа далд явагддаг гэр бүлийн хүчирхийллээс ялгаатай юм. Улмаар энэ төрлийн хүчирхийлэлд гэр бүлийн хүчирхийллийг бууруулах арга хэмжээ, хөтөлбөр дам байдлаар эерэг нөлөө үзүүлж чадах ч шийдвэрлэх арга хэрэгсэл болж чадахааргүй байгаа юм. Гуравдугаарт, залуу хүмүүсийн дунд гарсан зөрчлийг шийдвэрлэх, ярилцаж буруу үйлдлийг ухамсарлуулах, цаашилбал, арга хэмжээ авах тогтолцоо алга байгаа нь эрсдэлт хүчин зүйлийн нөлөөг даамжруулах нөхцөл болж мэдэх юм.

Судалгааны зөвлөхөөр ажилласан нийгмийн эрүүл мэндийн судлаач багш Б.Ариунсанаагийн арга зүйн болон агуулгын дэмжлэг нь судалгааны туршлага багатай иргэний нийгмийнхэнд

Улаанбаатар марафон - 2014.



маш өгөөжтэй байлаа. Харин хөтөлбөрөө анх төлөвлөхдөө 15-25 насны залуучуудыг зорилтот бүлэг болгож авсан нь арга зүйн алдаа болох нь ажиглагдлаа. 18-аас доош насны өсвөр насныхан голдуу эцэг эх, багш нарын хараа хяналт дор байдаг ба тэдэнд сургууль, орон нутгаар дамжуулан өөрийгөө хөгжүүлэх, багаар ажиллах, орон нутагтаа тусламж дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа агуулсан чөлөөт цагийн хөтөлбөр санал болгохыг олон улсын туршлага зөвлөж байна. Энэ зөвлөмжийн дагуу бид ирэх жилийн үйл ажиллагаагаа төлөвлөж байна. Харин 20-25 насныханд бие даасан амьдралтай болсон байдаг тул мэргэжил олгох, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, иргэний оролцоог хангах чиглэлийн үйл ажиллагааг илүү сонирхдог байна.

2014 онд “Өөрчлөлтийн төлөө залуу эмэгтэйчүүд” төрийн бус байгууллагын чадавхыг бэхжүүлэх зорилгоор байгууллага дэмжих тэтгэлэг олголоо. Тэтгэлгийн хүрээнд байгууллагынхаа түүх, туршлага, цаашдын зорилт, хөгжлийн хэрэгцээгээ дүгнэн хэлэлцэхэд нь дэмжлэг болгож семинар явуулахын зэрэгцээ судалгааны арга зүй, бодлогын нөлөөллийн зарчмуудыг танилцууллаа. “Өөрчлөлтийн төлөө залуу эмэгтэйчүүд” төрийн бус байгууллага нь дунд хугацааны стратегиа боловсруулж гаргаад байгаа ба сонирхол, туршлагадаа тулгуурлан гэмт хэрэгт холбогдсон насанд хүрээгүй хүүхдийн талаар баримтлах бодлогыг судлах явцдаа бодлогын судалгааны арга зүйн чадавхаа хөгжүүлж байна.



• САНХҮҮЖИЛТ

• АЖИЛТНУУД

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нээлттэй Нийгэм Форум 2014 онд нийт 1,400,000 ам.долларын төсөвтэй ажилласан ба үүнээс \$ 1,175,000 Нээлттэй Нийгэм Хүрээлэн болон Соросын сангийн сүлжээний хөтөлбөрүүдээс, \$ 66,000-Хууль зүйн яамнаас, \$ 56,000 Дэлхийн Нөөцийн Хүрээлэнгээс, \$ 52,000-Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгаас, \$ 51,000 бусад донор байгууллагын санхүүжилт байв. Төсвийн зарцуулалтыг задаргааг доор хүснэгтээр харуулав.

НИЙТ ЗАРЦУУЛАЛТ

\$ доллар

Хөтөлбөр	Тэтгэлгийн зардал	Үйл ажиллагааны зардал	Нийт зардал
ЗАСАГЛАЛЫН ХӨТӨЛБӨР			
Хүний эрх	-	21,801	21,801
Хууль сахиулах үйл ажиллагааны ил тод байдал	2,840	111,344	114,184
Хууль эрх зүйн шинэтгэл	-	12,910	12,910
Шүүхийн хараат бус байдал	4,221	39,820	44,041
Улс төрийн санхүүжилт	27,093	29,302	56,395
Төрийн ил тод хариуцлагатай байдал			
- Мэдээллийн эрх чөлөө	1,055	-	1,055
- Хариуцлагатай байдлыг бэхжүүлэх механизм	3,224	-	3,224
- Иргэний нийгмийн чадавхыг бэхжүүлэх	84,683	109,969	194,652
- Байгаль орчны талаар мэдээлэл авах иргэдийн эрх - STRIPE	28,023	7,769	35,792
ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ХӨТӨЛБӨР			
Олборлох үйлдвэрлэлийн засаглал, ил тод байдал	19,634	61,713	81,347
Төсвийн ил тод байдал ба иргэдийн оролцоо	21,494	41,736	63,230
Эдийн засгийн дүн шинжилгээ ба Бизнесийн орчин	-	7,670	7,670
Төрийн өмчит компаниудын засаглал			
- Төрийн өмчит уул уурхайн компаниудын засаглал	-	15,652	15,652
- Төрийн өмчит эрчим хүчний компаниудын засаглал	-	9,978	9,978
БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН ХӨТӨЛБӨР			
Тэгш хамруулах боловсрол	32,975	22,098	55,073
Бага насны хүүхдийн хөгжил	33,065	41,581	74,646
Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх нь	27,938	11,055	38,993
ЗАХИРГАА	-	512,437	512,437
НИЙТ ДҮН	286,245	1,056,835	1,343,080

ТЭТГЭЛГИЙН НИЙТ ЗАРЦУУЛАЛТ

\$ доллар

Хөтөлбөр	Байгууллагад олгосон	Хувь хүнд олгосон	Нийт зардал
ЗАСАГЛАЛЫН ХӨТӨЛБӨР			
Хүний эрх	-	-	-
Хууль сахиулах үйл ажиллагааны ил тод байдал	-	2,840	2,840
Хууль эрх зүйн шинэтгэл	-	-	-
Шүүхийн хараат бус байдал	4,221	-	4,221
Улс төрийн санхүүжилт	27,093	-	27,093
Төрийн ил тод хариуцлагатай байдал			
- Мэдээллийн эрх чөлөө	1,055	-	1,055
- Хариуцлагатай байдлыг бэхжүүлэх механизм	3,224	-	3,224
- Иргэний нийгмийн чадавхыг бэхжүүлэх	38,451	46,232	84,683
- Байгаль орчны талаар мэдээлэл авах иргэдийн эрх - STRIPE	6,113	21,910	28,023
ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ХӨТӨЛБӨР			
Олборлох үйлдвэрлэлийн засаглал, ил тод байдал	16,590	3,044	19,634
Төсвийн ил тод байдал ба иргэдийн оролцоо	21,494	-	21,494
Эдийн засгийн дүн шинжилгээ ба Бизнесийн орчин	-	-	-
Төрийн өмчит компаниудын засаглал			
- Төрийн өмчит уул уурхайн компаниудын засаглал	-	-	-
- Төрийн өмчит эрчим хүчний компаниудын засаглал	-	-	-
БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН ХӨТӨЛБӨР			
Тэгш хамруулах боловсрол	32,975	-	32,975
Бага насны хүүхдийн хөгжил	24,500	8,565	33,065
Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх нь	27,938	-	27,938
НИЙТ ДҮН	203,654	82,591	286,245

2013 ОНД ОЛГОСОН НИЙТ ТЭТГЭЛГИЙН ЖАГСААЛТ

\$ доллар

	Байршил	Тэтгэлэг хүртэгчийн нэр	Төрөл	Тэтгэлгийн дүн
1	Дархан-Уул аймаг	Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн хөдөлгөөн	ТББ	2,686
2	Дорнод аймаг	Буйр нуур, Халх гол, Нөмрөгийн сав газрыг хамгаалах хөдөлгөөн	ТББ	3,479
3	Дорнод аймаг	Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан	ТББ	2,560
4	Дорнод аймаг	Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн хөдөлгөөн	ТББ	2,608
5	Дорнод аймаг	Улс төрийн боловсролын академи	ТББ	2,609
6	Орхон аймаг	Төр иргэн түншлэл	ТББ	3,118
7	Өвөрхангай аймаг	Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан	ТББ	3,130
8	Өмнөговь аймаг	Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн хөдөлгөөн	ТББ	3,815
9	Улаанбаатар хот	Байгаль орчны төлөөх хуульчдын холбоо	ТББ	3,624
10	Улаанбаатар хот	Бодлогод залуусын хяналт	ТББ	4,552
11	Улаанбаатар хот	Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг	ТББ	17,477
12	Улаанбаатар хот	Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг	ТББ	24,500
13	Улаанбаатар хот	Глоб интернэшнл	ТББ	1,055
14	Улаанбаатар хот	Глоб интернэшнл	ТББ	1,750
15	Улаанбаатар хот	Гэгээ мандал сан	ТББ	4,415
16	Улаанбаатар хот	Захиргааны шинэ санаачилга	ТББ	2,895
17	Улаанбаатар хот	Ил тод байдал сан	ТББ	3,624
18	Улаанбаатар хот	Их бага Баян шарга	ТББ	3,377
19	Улаанбаатар хот	Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан	ТББ	5,248
20	Улаанбаатар хот	Марал элч	ТББ	2,586
21	Улаанбаатар хот	МИДАС	ТББ	1,450
22	Улаанбаатар хот	МИДАС	ТББ	16,944
23	Улаанбаатар хот	Монголын газрын тосны инженерүүдийн нийгэмлэг	ТББ	2,686
24	Улаанбаатар хот	Монголын сайн дурынхны төв	ТББ	4,477
25	Улаанбаатар хот	Монголын Чөлөөт Нийгмийн ажилтны төв	ТББ	3,601
26	Улаанбаатар хот	Монфемнет	ТББ	1,624
27	Улаанбаатар хот	Нийгмийн ажлын үйлчилгээ, үнэлгээний төв	ТББ	4,110
28	Улаанбаатар хот	Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн хөдөлгөөн	ТББ	5,248
29	Улаанбаатар хот	Ногоон дэлхий ба байгаль орчин	ТББ	3,292
30	Улаанбаатар хот	Онол арга	ТББ	3,160
31	Улаанбаатар хот	Өөрчлөлтийн төлөөх залуу эмэгтэйчүүд	ТББ	3,624
32	Улаанбаатар хот	Өөрчлөлтийн төлөөх залуу эмэгтэйчүүд	ТББ	6,447
33	Улаанбаатар хот	Өөрчлөлтийн төлөөх залуу эмэгтэйчүүд	ТББ	1,450
34	Улаанбаатар хот	Сонгино бие даан амьдрах төв	ТББ	3,526
35	Улаанбаатар хот	Сонгогчдын боловсрол төв	ТББ	3,224

	Байршил	Тэтгэлэг хүртэгчийн нэр	Төрөл	Тэтгэлгийн дүн
36	Улаанбаатар хот	Сонгогчдын боловсрол төв	ТББ	1,450
37	Улаанбаатар хот	Төмөр сан	ТББ	3,467
38	Улаанбаатар хот	Транспэрэнси интернэшнл	ТББ	4,050
39	Улаанбаатар хот	Тэргэнцэртэй иргэдийн холбоо	ТББ	3,624
40	Улаанбаатар хот	Тэргэнцэртэй иргэдийн холбоо	ТББ	851
41	Улаанбаатар хот	ХБИ-ийн байгууллагуудын үндэсний холбоо	ТББ	2,787
42	Улаанбаатар хот	Хил хязгааргүй алхам	ТББ	3,624
43	Улаанбаатар хот	Хил хязгааргүй алхам	ТББ	3,755
44	Улаанбаатар хот	Хөвсгөл далай эзэд хөдөлгөөн	ТББ	3,624
45	Улаанбаатар хот	Хөвсгөл далай эзэд хөдөлгөөн	ТББ	18,345
46	Улаанбаатар хот	ХБ-тэй хүүхдүүдийн эцэг эхийн холбоо	ТББ	12,912
47	Улаанбаатар хот	Хүний эрх хөгжил төв	ТББ	3,624
48	Улаанбаатар хот	Хүний эрх хөгжил төв	ТББ	3,566
49	Улаанбаатар хот	Хүнсний тусгаар байдлын төлөө хүмүүсийн эвсэл	ТББ	11,500
50	Улаанбаатар хот	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв	ТББ	1,624
51	Улаанбаатар хот	Хэрэглээний сэтгэл судлалын хүрээлэн	ТББ	3,936
52	Улаанбаатар хот	Эмнести интернэшнл	ТББ	4,221
53	Ховд аймаг	Ховд бат итгэл	ТББ	2,606
54	Хөвсгөл аймаг	Итгэлийн бяцхан илч	ТББ	2,655
55	Хөвсгөл аймаг	Хөвсгөлийн хөгжил, дэвшилд	ТББ	2,371
56	Улаанбаатар хот	А.Саруул	иргэн	1,294
57	Улаанбаатар хот	Б.Баттүвшин	иргэн	1,294
58	Улаанбаатар хот	Б.Уранхүрэл	иргэн	2,495
59	Улаанбаатар хот	Б.Урнаа	иргэн	2,840
60	Улаанбаатар хот	Д.Бэрцэцэг	иргэн	225
61	Улаанбаатар хот	Д.Дорждэрэм	иргэн	1,294
62	Улаанбаатар хот	Д.Чимгээ	иргэн	425
63	Улаанбаатар хот	Ё.Гэрэлчулуун	иргэн	1,294
64	Улаанбаатар хот	Л.Ариун	иргэн	2,495
65	Улаанбаатар хот	Л.Долгормаа	иргэн	6,113
66	Улаанбаатар хот	Л.Төр-Од	иргэн	1,522
67	Улаанбаатар хот	Л.Төр-Од	иргэн	1,294
68	Улаанбаатар хот	Н.Баярсайхан	иргэн	1,522
69	Улаанбаатар хот	Н.Мөнхтуяа	иргэн	3,575
	НИЙТ			286,245

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД, АЖИЛТНУУД

Нээлттэй Нийгэм Форумын Удирдах Зөвлөлийн гишүүд

Г. Уранцоож	УЗ-ийн дарга, Хүний эрх хөгжил төвийн тэргүүн
Ж. Үнэнбат	УЗ-ийн гишүүн, Компанийн засаглалын хөгжлийн төв ТББ-ын гүйцэтгэх захирал
Ч. Хашчулуун	УЗ-ийн гишүүн, МУИС-ийн ЭЗС-ийн багш
Ч. Лодойравсал	УЗ-ийн гишүүн, МУИС-ийн МТС-ийн багш
Ц. Отгонбаатар	УЗ-ийн гишүүн, ЛГБТ төвийн захирал
О. Энхтуяа	УЗ-ийн гишүүн, Дэ Нэйчэр консерванси ТББ-ын захирал

Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх захирал

П. Эрдэнэжаргал	jargal@forum.mn
-----------------	-----------------

Нээлттэй Нийгэм Форумын ажилтнууд

П. Бадамрагчаа	Засаглалын хөтөлбөрийн менежер	badmaa@forum.mn
Б. Баттуул	Засаглалын хөтөлбөрийн менежер	battuul@forum.mn
А. Гэрэлмаа	Нийгэм, Боловсролын хөтөлбөрийн менежер	gerelmaa@forum.mn
Д. Оюунбадам	Эдийн засгийн хөтөлбөрийн менежер	oyunbadam@forum.mn
Ж. Оюунтүлхүүр	Засаглалын хөтөлбөрийн менежер	oyuna@forum.mn
Б. Хишигсайхан	Засаглалын хөтөлбөрийн менежер	khishgee@forum.mn
Б. Цолмон	Засаглалын хөтөлбөрийн менежер (2014 оны 9 сар хүртэл ажилласан)	
Д. Эрдэнэчимэг	Эдийн засгийн хөтөлбөрийн менежер	dorjdari@forum.mn
О. Сэлэнгэ	Хөтөлбөрийн туслах ажилтан	passistant@forum.mn
У. Энхцэцэг	Хөтөлбөрийн туслах ажилтан	assistant@forum.mn
Б. Үүрийнтуяа	Хөтөлбөрийн туслах ажилтан	fellowship@forum.mn
Д. Балжид	Мэдээллийн менежер	baljid@forum.mn
Д. Баярмаа	Мэдээллийн ажилтан (2014 оны 6 сар хүртэл ажилласан)	
Б. Мөнхгэрэл	Сэтгүүлч	munkhgerel@forum.mn
Д. Жавхлан	Санхүүгийн захирал	javkhlan@forum.mn
Д. Аюуш	Оффис, тэтгэлгийн менежер	ayush@forum.mn
Г. Одонмижид	Нягтлан бодогч	odnoo@forum.mn
Э. Сайнтувшин	Мэдээлэл сүлжээний зохицуулагч	sainaa@forum.mn
Д. Ганзул	Захирлын туслах	reception@forum.mn
Б. Баатар	Захиргааны ажилтан	baatar@forum.mn
Г. Цэдэвхүү	Захиргааны ажилтан	tsedev@forum.mn
Н. Хүрэлболд	Захиргааны ажилтан	
С. Солонго	Захиргааны ажилтан (2014 оны 7 сар хүртэл ажилласан)	

Нийтлэг И-мэйл: osf@forum.mn